

## **БАНКИНД АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

### **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэ журмаар банк Банкны тухай хууль, тогтоомж, Монголбанкнаас баталсан дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол банкны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авах, тогтворжуулах төлөвлөгөө, банкны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэх, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, банкийг татан буулгах шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Монголбанк нь тухайн зөрчил, дутагдал, үүссэн нөхцөл, шаардлагад тохирсон арга хэмжээ авах зарчмыг баримтална.
- 1.3. Банкинд албадлагын арга хэмжээ авах журам болон энэ журамтай нийцүүлэн гаргасан бусад журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 1.3.1. “Тогтворжуулах төлөвлөгөө” гэж Банкны тухай хуулийн 47.1-д заасныг;
  - 1.3.2. “Тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед авах арга хэмжээ” гэж санхүү, төлбөрийн чадварын эрсдэлд орох, цаашилбал банкны татан буугдах эрсдэлийг бууруулах, банкны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд буцаан нийцүүлэх арга хэмжээг;
  - 1.3.3. “Эрх бүхий байгууллага” гэж Монголбанк, Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци болон тухайн банкинд зохицуулалт хийдэг бусад төрийн байгууллагыг;
  - 1.3.4. “Банкны нөхцөлт удирдлага” гэж Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар банкны хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөл бүрдээгүй эсхүл төлбөрийн чадвар нь муудаж байгаа нь Монголбанкны хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөлд тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор банкны удирдлага, зохион байгуулалт, санхүү, үйл ажиллагаатай нь холбогдуулан хуульд заасны дагуу Монголбанкнаас хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;
  - 1.3.5. “Банкны төлбөрийн чадварын хүндрэл” гэдэг нь банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөнөөс Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тодорхой хугацааны турш биелүүлэхгүй байх эсхүл биелүүлж чадахгүй байхыг<sup>1</sup>;

---

<sup>1</sup> Банкны тухай хуулийн 54.1.1, 54.3.1 дэх заалт

- 1.3.6. "Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ" гэж Банкны тухай хуулийн 3.1.3-д заасан банкны бүтэц, зохион байгуулалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах, түүнийг нэмэгдүүлэх буюу хорогдуулах зэргээр санхүүгийн байдлыг нь сайжруулж, алдагдлыг багасгах зорилгоор удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн болон холбогдох бусад цогцолбор арга хэмжээ авахыг;
- 1.3.7. "Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний төлөвлөгөө" гэж Банкны тухай хуульд заасан бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслийг ашиглан банкинд түүнийг хэрэгжүүлэх талаар тус хуулийн 47.5-д заасны дагуу Монголбанкнаас боловсруулж баталсан төлөвлөгөөг;
- 1.3.8. "Банкийг татан буулгах" гэж Банкны тухай хуулийн 68.1-д зааснаар банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон эсхүл бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай Монголбанкны шийдвэр гарснаар банк, түүний удирдлагын бүрэн эрх, банкны хөрөнгийг захиран зарцуулах эрх, хяналтыг Банкны эрх хүлээн авагчид бүрэн шилжүүлэн Банкны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 5 дугаар дэд бүлэгт заасан арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг<sup>2</sup>;
- 1.3.9. "Бүрэн эрхт төлөөлөгч" гэж /цаашид БЭТ гэх/ банкны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхээр Монголбанкнаас томилогдсон банкны удирдлагын бүрэн эрхийг шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээдийг;
- 1.3.10. "Тусгай төлөөлөгч" гэж /цаашид ТТ гэх/ банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр Монголбанкнаас томилогдсон банкны удирдлага, банкны хөрөнгийг захиран зарцуулах эрхийг шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээдийг;
- 1.3.11. "Банкны эрх хүлээн авагч" /цаашид БЭХА гэх/ гэж банкныг татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэхээр Монголбанкнаас томилсон иргэн, хуулийн этгээдийг;
- 1.4. Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр Монголбанкнаас томилсон БЭТ, ТТ, БЭХА болон дараахь шаардлагыг хангасан байна:
  - 1.4.1. Банкны үйл ажиллагааны мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвартай;
  - 1.4.2. Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй;
  - 1.4.3. Тухайн банкнаас урьд нь авсан хугацаа хэтэрсэн зээлийн өргүй;
  - 1.4.4. Тухайн банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтантай холбогдох этгээдийн харилцаагүй.
- 1.5. Хуулийн этгээд бол өөрийн үйл ажиллагааг хариуцах хангалттай хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй байхаас гадна уг хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь энэ журмын 1.5-д заасан шаардлагыг хангасан байна.
- 1.6. Банкны үйл ажиллагааны цар хүрээ, эрсдэлийн түвшингээс хамаарч БЭТ, ТТ, БЭХА нь Монголбанкнаас томилогдсон 3-аас доошгүй гишүүдээс бүрдсэн зөвлөлтэй байна. Зөвлөл нь дараахь чиглэлийн мэргэшсэн гишүүдтэй байх бөгөөд гишүүд нь давхар чиглэл хариуцаж болно:
  - 1.6.1. Эрх зүйч;
  - 1.6.2. Хадгаламжийн даатгалын корпорацийн төлөөлөл;

---

<sup>2</sup> БТХ-ийн 68.2-ыг яаж ойлгох вэ!!!! Нөхөн төлбөр !!!

- 1.6.3. Банк, санхүү, зээлийн мэргэжилтэн;
- 1.6.4. Мэдээллийн технологийн мэргэжилтэн;
- 1.6.5. Бусад шаардлагатай мэргэжилтэн.
- 1.7.БЭТ, ТТ, БЭХА-ийн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг БЭТ, ТТ, БЭХА тогтоох, өөрчлөх эрхтэй. Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан үлгэрчилсэн загварыг ашиглан гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоож болно.
- 1.8.БЭТ, ТТ, БЭХА болон зөвлөлийн гишүүдийн ажиллах нөхцөл, аюулгүй байдал (гэр бүлийн гишүүд), ажлын байр, орон тоог хадгалах, нийгмийн хангамж зэрэг бусад асуудлыг Монголбанктай байгуулах гэрээгээр зохицуулна.
- 1.9.БЭТ, ТТ, БЭХА арга хэмжээг хэрэгжүүлж байгаа банкны орон нутаг дахь нэгжийн үйл ажиллагаанд тухайн орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын захирал хяналт тавьж ажиллана.
- 1.10. Банкны тухай хуульд заасны дагуу БЭТ, ТТ, БЭХА болон зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг албадлагын арга хэмжээ авч буй банкны гүйцэтгэх удирдлагын цалин, хөлс, урамшуулал, бусад нөхцөлтэй уялдуулан Монголбанкнаас тогтооно.
- 1.11. БЭТ, ТТ, БЭХА нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас гаргасан заавар, журам, шийдвэр, Монголбанкны удирдлагатай байгуулсан гэрээ болон энэ журмыг баримтална.
- 1.12. БЭТ, ТТ, БЭХА нь үйл ажиллагаандаа тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.13. БЭТ, ТТ, БЭХА нь тайлан тэнцлийн холбогдох дансдын үлдэгдэл бодит байдал болон үндсэн баримттай зөрүүтэй тохиолдолд банкны гүйцэтгэх удирдлага, холбогдох бусад этгээдээс тодруулга авах, баримтжуулах, холбогдох тохируулгын гүйлгээг хийх, шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

### **Хоёр. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл**

- 2.1. Банкны тухай хуулийн 48.1-д заалтад заасан арга хэмжээг дараахь нөхцөл, тохиолдолд авна:
  - 2.1.1. Банкны тухай хууль болон холбогдох журмын дагуу банкинд тавих шаардлага, банкны үйл ажиллагаанд тавигдах аливаа хязгаарлалт болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй;
  - 2.1.2. Банкны тухай хууль, тогтоомжид заасан мэдээллийг бүрэн болон хэсэгчлэн гаргаж өгөөгүй, гаргаж өгсөн мэдээлэл нь бодит байдалтай нийцэхгүй, худал, хөндлөнгийн аудитын компаниар аудитын шалгалт хийлгүүлээгүй, хөндлөнгийн аудитын тайлан, мэдээг худал мэдээлсэн бол;
  - 2.1.3. Монголбанкнаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
  - 2.1.4. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай мэдээллийг “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн дагуу Монголбанкинд ирүүлээгүй, олон нийтэд ил тод байдлаар зарлаагүй;

- 2.1.5. Хувьцаа эзэмшигчийн эдийн засгийн бусад хэлцлээс шалтгаалан банкны санхүүгийн тогтвортой байдал, харилцах, хадгаламж эзэмшигч нарт сөргөөр нөлөөлөх тухай мэдээллийг Монголбанкинд ирүүлээгүй;
- 2.1.6. Монголбанкнаас хийсэн газар дээрх болон зайны хяналт шалгалт, дүн шинжилгээний явцад харилцах, хагаламж эзэмшигч нарын эрх ашиг зөрчигдөх, банкны системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл, байдал бүрдсэн гэж дүгнэсэн тохиолдолд.
- 2.1.7. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад.

### **Гурав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах**

- 3.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн хугацаа нь зөрчлийг илрүүлж, тогтоосон хугацаанаас эхэлнэ.
- 3.2. Банкинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч, Хяналт шалгалтын чиг үүрэг бүхий удирдлага, Монголбанкны Улсын байцаагч нар гаргана.
- 3.3. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан нь Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжоор Монголбанкнаас арга хэмжээ авах, хариуцлага ногдуулах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- 3.4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахдаа тодорхой тоон хязгаарыг тогтоож, тэдгээрийн хэрэгжилтээс хамааран урьдчилан сэргийлэх дараагийн шатны арга хэмжээг ажлын 14 хоногийн дотор багтаан бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.5. Тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд энэ журмын 2 дугаар бүлгийг, Банкны нөхцөлт удирдлагын арга хэмжээг авахад энэ журмын 3 дугаар бүлгийг тус тус баримтална.
- 3.6. Монголбанкнаас Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т заасны дагуу банкинд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Хадгаламжийн даатгалын корпорацид жил бүрийн 4, 10 дугаар сард багтаан мэдэгдэнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **БАНКНЫ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ**

#### **Дөрөв. Тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, түүнд тавигдах шаардлага**

- 4.1. Банк тогтворжуулах төлөвлөгөөг боловсруулахад банкны тухай хууль, тогтоомж болон бусад эрх бүхий байгууллагын шаардлагад нийцүүлнэ.
- 4.2. Тогтворжуулах төлөвлөгөө нь тухайн банкны нэгдэл, түүний толгой компанийн үйл ажиллагааг хамарсан байна.
- 4.3. Тогтворжуулах төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, туршилт хийх, түүний үр дүнд хариу арга хэмжээ авах ажлыг банкны гүйцэтгэх удирдлага удирдан зохион байгуулна.
- 4.4. Тогтворжуулах төлөвлөгөө нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:

- 4.4.1. Банкны санхүүжилт, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орж болзошгүй эрсдэл үүсэх магадлалыг урьдчилан тооцож, хэрэв тохиолдол үүсвэл авах хариу арга хэмжээг нарийвчлан тусгасан байх;
  - 4.4.2. Банк нь эрсдэлийн сорилын үр дүнд эдийн засгийн суурь болон сөрөг нөхцөл байдлын үед зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах эсэх, хүлээж болзошгүй эрсдэлийн дүнг материаллаг хэмжээнд хүрэхэд банкны төлбөрийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хэрхэн хадгалж ажиллах талаар нарийвчлан тусгасан байх;
  - 4.4.3. Банкны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, өөрийн хөрөнгийн төлөвлөгөө, банкны дотооддоо өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын хүрэлцээг үнэлэх үйл явц, эрсдэлийн удирдлага болон эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээтэй уялдсан байх;
- 4.5. Тогтворжуулах төлөвлөгөө нь банкны Дотоод аудитын заавал шалгах бодлогын баримт бичиг байна.

#### **Тав. Тогтворжуулах төлөвлөгөө хэрэгжүүлэх тохиолдлууд**

- 5.1. Дараахь чанарын болон тоон үзүүлэлтүүд нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдахад сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дүн гарвал урьдчилан анхааруулах дохио болох бөгөөд тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх эсэхэд анхаарна:
- 5.1.1. Банкны тухай хууль болон холбогдох журмын дагуу банкинд тавигдах аливаа үйл ажиллагааны хязгаарлалт болон зохистой харьцаа алдагдах, эсхүл алдагдах магадлал бий болох;
  - 5.1.2. Банкны хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсноор банкинд сөрөг нөхцөл байдал бий болох;
  - 5.1.3. Эдийн засаг, санхүү, банкны салбар бүхэлдээ эсхүл хэсэгчлэн хүндрэлд орох;
  - 5.1.4. Банкны өмнөх оны төсөвт хийгдсэн суурь болон сөрөг нөхцөлд байдалд хийгдсэн шинжилгээний хариу сөрөг гарах;
  - 5.1.5. Харилцагчийн болон гэрээний үүргийн дагуу гадаад валютаар гүйлгээг хийх боломжгүй болох;
  - 5.1.6. Банкны зээлжих зэрэглэл буурах;
  - 5.1.7. Банкны харилцагч, гадаадын банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн гэрээний дагуу тавьсан шалгуур үзүүлэлтүүд доод хэмжээнд удаа дараалан тулж очих, уг үзүүлэлтүүд зөрчигдөж эх үүсвэр буцаан дуудагдах эрсдэл үүсэх;
  - 5.1.8. Банкны ашиг, зээлийн чанар, бусад санхүүгийн чанарын үзүүлэлтүүд муудах;
  - 5.1.9. Харилцагч банк, санхүүгийн байгууллага нь байршуулсан хөрөнгөндөө нэмэлт барьцаа хөрөнгө шаардах, шинээр хийгдэх хэлцлээс татгалзах;
  - 5.1.10. Бусад банкуудын төлбөрийн чадвар муудах;
  - 5.1.11. Дотоодын захас дахин санхүүжилт авах, хугацааг сунгахад хүндрэлтэй болох;
  - 5.1.12. Банкны талаар сөрөг мэдээлэл олон нийтэд цацагдсанаас эрсдэл үүсэх;
  - 5.1.13. Харилцагч банк нь зээлийн шугамаа бууруулах, хаах;
  - 5.1.14. Зээл өсөлтийг тогтворгүй, богино хугацаат эх үүсвэрээр санхүүжүүлэх;

- 5.1.15. Актив, пассивын хэт төвлөрөл бий болох;
- 5.1.16. Актив, пассивын төлөгдөх хугацааны зөрүү ихсэх;
- 5.1.17. Зах зээл дээрх хүүгийн огцом өөрчлөлт үүсэх;
- 5.1.18. Хадгаламжийн гарах урсгал нэмэгдэх;
- 5.1.19. Хугацаат хадгаламж хугацаанаас өмнө татагдах;
- 5.1.20. Бусад эрсдэл бүхий тохиолдол үүсэх.

### **Зургаа. Тогтворжуулах төлөвлөгөөг турших, хэрэгжүүлэх**

- 6.1. Төлөвлөгөөг хамгийн багадаа хагас жилд нэг удаа турших бөгөөд туршилтыг хэсэгчилэн хийж болно. Туршилт хийхдээ тулгамдсан ямар нэг хүндрэлийг зохиомлоор бий болгож, банкны удирдлага болон бүх нэгжүүдэд хэрхэн арга хэмжээ авч байгааг шалгаж, төлөвлөгөөг дүгнэн, шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулна.
- 6.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн, туршилт хийсэн, үр дүнг дүгнэсэн талаар банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана.
- 6.3. Тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөхцөл үүсэхэд банкны удирдлагын зүгээс урьдчилан тодорхойлсон арга хэмжээ тохиромжтой эсэх, батлагдсан төлөвлөгөө нь тухайн үеийн бодлогын баримт бичигт нийцтэй эсэхэд дахин хянаж, банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тухай бүр богино хугацаанд танилцуулан батлуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан тогтооно.
- 6.4. Бусад нэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **Долоо. Тогтворжуулах төлөвлөгөөг батлах, албадлагын арга хэмжээ авах**

- 7.1. Монголбанк нь Банкны тухай хуулийн 47.3-т заасны дагуу банкнаас ирүүлсэн тогтворжуулах төлөвлөгөөг шаардлага хангасан эсэхэд хяналт тавих бөгөөд дараахь хуваарийн дагуу ажиллана:
  - 7.1.1. Банк нь жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дараа жилийн банкны тогтворжуулах төлөвлөгөө, тухайн жилийн тогтворжуулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн хамт Монголбанкинд хүргүүлнэ;
  - 7.1.2. Монголбанк нь банкнаас ирүүлсэн тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор дүгнэлт гаргаж, банкинд хариу мэдэгдэнэ. Хэрэв уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор шаардлага хангасан төлөвлөгөөг дахин ирүүлэхийг шаардана.
- 7.2. Банк энэ журмын 7.1.2-т заасны дагуу тогтворжуулах төлөвлөгөөнд зохих өөрчлөлтийн оруулаагүй буюу уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл Монголбанкнаас Банкны тухай хуулийн 47.4 дэх заалтад заасан шаардлагыг тавина.
- 7.3. Энэ журмын 5.1-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Монголбанкнаас Банкны тухай хуулийн 48.1.3-д заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч болно.
- 7.4. Энэ журмын 7.2. 7.3-д заасан тохиолдол үүсвэл Банкны тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг авч болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

## БАНКНЫ НӨХЦӨЛТ УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

### Найм. Банкны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэх үндэслэл, шийдвэр<sup>3</sup>

- 8.1. Монголбанк нь дараахь үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд банкны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна:
  - 8.1.1. Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн шаардлага, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн аль нэгийг 6 сар дараалан хангаагүй, эсхүл сүүлийн 12 сарын хугацаанд 6-аас доошгүй удаа зөрчсөн бол;
  - 8.1.2. Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн аль нэгийг 40-өөс дээш хувиар хангахгүй болсон бол;
  - 8.1.3. Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үр дүнд хүрээгүй бол.
- 8.2. Энэ журмын 8.1-д заасан үндэслэл бий болсон нь Монголбанкнаас тухайн банкинд хийгдсэн газар дээрх болон зайнаас хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон тохиолдолд Монголбанкны Хяналт шалгалтын хорооны зөвлөмжийг харгалзан Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх тухай Монголбанкны Ерөнхийлөгч шийдвэр гаргана.
- 8.3. Монголбанкнаас тухайн банкинд Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлж эхэлсэн тухай олон нийтэд мэдээлж болно.
- 8.4. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх тухай Монголбанкны шийдвэр нь Банкны тухай хуулийн 50.1 дэх<sup>4</sup> заалтад заасан шаардлагыг хангахаас гадна Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор дараахь шийдвэрийг гаргана:
  - 8.4.1. Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлж, цалин, нөхөн олговор, бусад хангамжийг зогсоох;
  - 8.4.2. Шаардлагатай тохиолдолд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх;
  - 8.4.3. Бүрэн эрхт төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг томилох<sup>5</sup> (энэ журмын дөрөвдүгээр хавсралт);
  - 8.4.4. Бүрэн эрхт төлөөлөгчийн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажлын удирдамж (энэ журмын нэгдүгээр хавсралт);
  - 8.4.5. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлж эхлэхэд Бүрэн эрхт төлөөлөгчид туслах ажлын хэсгийн удирдамж (энэ журмын хоёрдугаар хавсралт).

### Ес. Бүрэн эрхт төлөөлөгчийн эрх, үүрэг

- 9.1. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлж байгаа банкны удирдлагын бүрэн эрх Бүрэн эрхт төлөөлөгчид шилжинэ.

<sup>3</sup> Банкны тухай хуулийн 54.3-т банкны төлбөрийн чадваргүй болох гэдэгт төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдах, зохистой харьцааны үзүүлэлтийг хангаагүйгээс цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болох, өөрийн хөрөнгө алдагдах гэж тодорхойлсон байна.

<sup>4</sup> Банкны нэр, Банкны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэх үндэслэл, хугацаа, үйл ажиллагааны хязгаарлалт, Бүрэн эрхт төлөөлөгчийн нэр

<sup>5</sup> Банкны тухай хуулийн 53.3 дахь заалт...урьдчилан сэргийлэх арга хэмжээний.. хяналтыг Монголбанкны хяналтын чиг үүргээс тусад нь зохион байгуулна

- 9.2. Бүрэн эрхт төлөөлөгч нь Банкны тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан эрх хэмжээний хүрээнд Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэхдээ дор дурдсан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:
- 9.2.1. Өөрийн үйл ажиллагаандаа Банкны тухай болон бусад хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг дагаж мөрдөх;
- 9.2.2. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх тухай Монголбанкны шийдвэр, банкны удирдлагын эрх үүрэг Банкны бүрэн эрхт төлөөлөгчид шилжсэн тухай мэдэгдлийг 24 цагийн дотор тухайн банкны эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх;
- 9.2.3. Банкны газар, хэлтсийн захирал, салбар нэгжийн удирдлагын эрх, үүрэг, зардал гаргах эрх хэмжээг тогтоосон шийдвэр гаргаж мэдэгдэх<sup>6</sup>;
- 9.2.4. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлж эхлэх өдрийн өмнөх өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, шүүх, шийдвэр гүйцэтгэлийн алба болон бусад хууль хяналтын байгууллагаар хянагдаж, оролцож байгаа хэргүүд, бусад холбогдох тайлан, мэдээг банкны гүйцэтгэх удирдлага, санхүү хариуцсан эрх бүхий албан тушаалтан, ажилтнаар гарын үсэг зуруулж, тамга тэмдгээр баталгаажуулан хүлээн авах;
- 9.2.5. Бүрэн эрхт төлөөлөгчид туслах ажлын хэсгийг удирдлагаар хангаж, банкны тайлан тэнцэл, бичиг баримт, тэнцлийн гадуурх бүртгэлийг батлагдсан удирдамж, загварын дагуу гаргуулан авах (энэ журмын хоёрдугаар хавсралт);
- 9.2.6. Томилогдсоноос хойш 14 хоногийн дотор банкны гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан болон сүүлийн 2 жилийн хугацааг хамруулсан орлогын мэдүүлгийг тавдугаар хавсралтын дагуу гаргуулан авах;
- 9.2.7. Банкны тухай хуулийн 52.2-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### **Арав. Банкны хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээ<sup>7</sup>**

- 10.1. Бүрэн эрхт төлөөлөгч нь томилогдсоноосоо хойш ажлын 10 хоногийн дотор тухайн банкны санхүү, төлбөрийн чадварын байдалд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Монголбанкинд ирүүлнэ.
- 10.2. Монголбанк нь Бүрэн эрхт төлөөлөгчөөс ирүүлсэн санал дүгнэлтийг ажлын 10 хоногийн дотор хэлэлцэн тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээний төлөвлөгөөг батална.
- 10.3. Энэ арга хэмжээний төлөвлөгөө нь Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх үед Бүрэн эрхт төлөөлөгч болон банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах дараахь асуудлыг тусгасан байна:
- 10.3.1. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн дутагдлыг нөхөх хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, нэмэгдүүлэх арга зам;
- 10.3.2. Банкны актив, пассивын бүтцийг сайжруулах зорилгоор чанаргүй активыг сонирхогч иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах;

<sup>6</sup> Бүрэн эрхт төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр банкны нэрийн өмнөөс хийсэн болон банкны зардлаар хийсэн ажил гүйлгээг хүчингүйд тооцох тул /Банкны тухай хуулийн 52.5/ тодорхой хэмжээгээр эрх хэмжээ тогтоон өгөх нь зүйтэй.

<sup>7</sup> Банкны тухай хуулийн 52.8-т зааснаар Бүрэн эрхт төлөөлөгч нь өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж банкинд учруулсан хохирлыг хариуцахаар хуульчлагдсан тул ажлын удирдамж, авах арга хэмжээний төлөвлөгөөгөө Монголбанкаар батлуулах нь зүйтэй гэж үзлээ.



- 10.3.3. Шаардлагатай бол банкны нэгж, өмчилж буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах;
- 10.3.4. Алдагдал үүсгэж буй, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөрөг нөлөөтэй банкны зарим үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох;
- 10.3.5. Шаардлагатай гэж үзсэн банкны хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээ гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээг цуцлах, зээлийн хүү, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах;
- 10.3.6. Банкны бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг авах;
- 10.3.7. Банкны бизнесийн үйл ажиллагааг эрхлэхэд Бүрэн эрхт төлөөлөгчид олгогдох эрх, хязгаарлалтууд.
- 10.3.8. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахад шаардлагатай Бүрэн эрхт төлөөлөгчөөс авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээ;
- 10.3.9. Бусад.
- 10.4. Банкны төлбөрийн чадварыг сайжруулахад банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, гишүүдийг шинэчлэн томилох шаардлагатай гэж үзвэл Банкны тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монголбанк эсхүл Бүрэн эрхт төлөөлөгчийн санаачлагаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргана.
- 10.5. Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах шийдвэр нь компанийн тухай хуулийн 60, 61 дүгээр зүйл, Банкны тухай хуулийн 30 дугаар зүйлтэй нийцсэн байна.
- 10.6. Банкны тухай хуулийн 30.3 дахь заалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит буй хурлын шийдвэр нь бүрэн эрхт төлөөлөгчийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 10.7. Бүрэн эрхт төлөөлөгч нь Банкны хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээний төлөвлөгөө болон Банкны тухай хуулийн 52.2-д заасан эрх, үүргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.
- 10.8. Бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын удирдамж, энэ журмын 10.3-т заасан эрх хэмжээнд тусгагдаагүй боловч банкны хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авах бол Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг урьдчилан бичгээр авна.
- 10.9. Бүрэн эрхт төлөөлөгч нь шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас өгсөн чиглэлийн дагуу Банкны тухай хуулийн 43.3, 43.4-т тус тус зааснаар банкны үйл ажиллагааны бодит байдлыг тодорхойлох зорилгоор активын чанарын үнэлгээг хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр хийлгэх арга хэмжээг зохион байгуулна.<sup>8</sup> Үнэлгээ хийхэд гарсан зардлыг Монголбанк хариуцна.

### **Арван нэг. Банкны нөхцөлт удирдлагын арга хэмжээг дуусгавар болгох**

- 11.1. Монголбанк нь банкны санхүү төлбөрийн чадварын байдалд хийсэн Бүрэн эрхт төлөөлөгчийн дүгнэлт, ажилласан хугацааны тайланг үндэслэн дараахь тохиолдолд Банкны нөхцөлт удирдлагыг дуусгавар болгох шийдвэрийг гаргана:

---

<sup>8</sup> Банкны тухай хуулийн 56.7-д Тусгай төлөөлөгч нь актив, пассивын үнэлгээг хийлгэх үүрэгтэй бөгөөд тусгай төлөөлөгч нь дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд цаг хугацаа хожих боломжийг олгох зорилгоор энэ арга хэмжээг зохион байгуулах нь зохимжтой гэж үзлээ.

- 11.1.1. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлснээр тухайн банкны хэвийн үйл ажиллагаа хангагдсан нөхцөлд Монголбанк нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх арга хэмжээг цуцалж, тухайн банкинд тогтоосон хязгаарлалт, түдгэлзүүлсэн үйл ажиллагааг бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн сэргээсэн бол;
- 11.1.2. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлснээр банкны хэвийн үйл ажиллагаа хангах боломжгүй гэж үзэн банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, банкныг татан буулгахаар Монголбанкнаас шийдвэр гарсан бол;
- 11.1.3. Бүрэн эрхт төлөөлөгчийг томилсноос хойш 1жилийн хугацаа өнгөрсөн бол.
- 11.2. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж, санхүүгийн байдал сайжирсан бол Монголбанк тухайн банкны хэвийн үйл ажиллагаа хангагдсан гэж үзнэ.
- 11.3. Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх үед Бүрэн эрхт төлөөлөгчөөс гаргасан шийдвэр, банкны дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **БАНКНЫ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ**

#### **Арван хоёр. Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө**

- 12.1. Банкны тухай хуулийн 47.4, 48.1.3-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци хамтран тухайн банкинд Банкны тухай хуулийн 47.5-д заасан бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна<sup>9</sup>.
- 12.2. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд тухайн банк, банкны тогтолцоог хамарсан төлбөрийн чадвар алдагдаж болох нөхцөл байдал, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлсон таамаглалд үндэслэн авах арга хэмжээг тусгана.
- 12.3. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэхдээ энэ журмын гуравдугаар хавсралтад заасан аргачлалыг ашиглах бөгөөд тогтворжуулах төлөвлөгөөг харгалзан үзнэ.

#### **Арван гурав. Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах үндэслэл, шийдвэр, хамрах хүрээ**

- 13.1. Монголбанк нь дараахь нөхцөл бүрдсэн тохиолдолд Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авна:
  - 13.1.1. Банк төлбөрийн чадваргүй болсон эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэн;
  - 13.1.2. Монголбанкны хяналт шалгалтын дүгнэлтээр цаашид банкны хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй;
  - 13.1.3. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах нь нийтийн ашиг сонирхлыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.
- 13.2. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Банкны тухай хуулийн 53.3-т заасны дагуу банкны хяналт шалгалтаас тусад нь зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

---

<sup>9</sup> Банкны тухай хуулийн 53.3 дахь заалтыг анхаарах!!!

- 13.3. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх Тусгай төлөөлөгчийг томилно.
- 13.4. Банкнд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах тухай Монголбанкны шийдвэрт дараахь зүйлсийг тусгана:
- 13.4.1. Банкнд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах болсон үндэслэл;
- 13.4.2. Банкны нэр, оршин байгаа газар, хаяг;
- 13.4.3. Банкны үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох, түтгэлзүүлэх, чөлөөлөх тухай болон бусад шийдвэр, түүнд холбогдох жагсаалт;
- 13.4.4. Тусгай төлөөлөгчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр.
- 13.5. Банкнд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах тухай шийдвэрийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч дараахь шийдвэрүүдийг хамтад нь гаргана:
- 13.5.1. Банкны төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх;
- 13.5.2. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг шинэчлэх Монголбанкны ажлын хэсэг томилох;
- 13.5.3. Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг томилох;
- 13.5.4. Банкны удирдлага, хөрөнгийг тусгай төлөөлөгч шилжүүлэн авахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах ажлын хэсэг байгуулах;
- 13.5.5. Тусгай төлөөлөгчийн болон тусгай төлөөлөгчийн зөвлөлийн гишүүдийн цалин хөлс, холбогдох бусад зардал, банкны хөрөнгийг захиран зарцуулах зарчим, эрх мэдэл, хэмжээ, үйл ажиллагааны зардлын хэмжээг тогтоох<sup>10</sup> зөвшөөрөл олгосон шийдвэр.
- 13.6. Банкнд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах тухай шийдвэрийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч дараахь шийдвэрийг хамтад нь гаргаж болно:
- 13.6.1. Тусгай төлөөлөгчийн ажлын удирдамж, тусгай төлөөлөгчийн гишүүдийн ажил үүргийн хуваарь батлах;
- 13.6.2. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авч байгаа банкны орон нутгийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавихад Монголбанкны салбараас баримталж ажиллах удирдамж, чиглэл;
- 13.6.3. Олон нийтэд мэдээлэх мэдээллийг цэгцтэй, нэгдсэн бодлого, зохион байгуулалттай байлгах зорилгоор олон нийттэй харилцах төлөвлөгөөг батлах, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах албан тушаалтныг томилох (энэ журмын зургаадугаар хавсралт).
- 13.7. Монголбанк банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авсан тухай шийдвэрээ Хадгаламжийн даатгалын корпораци, Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.
- 13.8. Банкнд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн тухай мэдээллийг Монголбанкнаас олон нийтэд нэн даруй мэдээлнэ.

---

<sup>10</sup> БТХ-ийн 66.6 дугаар заалтад нийцүүлэхийн тулд энэ заалтыг оруулав. Тусгайлан энэ талаар ХЭЗГ-аас тайлбар авах!!

13.9. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг банк, түүний нэгдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.<sup>11</sup>

**Арван дөрөв. Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ**

14.1. Тусгай төлөөлөгч нь Банкны тухай хуулийн 56.8, 69.1-д заасан эрх хэмжээний хүрээнд Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

14.1.1. Өөрийн үйл ажиллагаандаа Банкны тухай болон бусад хууль тогтоомж, Монголбанкны шийдвэр, энэ журмыг дагаж мөрдөх;

14.1.2. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах тухай Монголбанкны шийдвэр, банкны удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх болон банкны хөрөнгийг захиран зарцуулах эрх Тусгай төлөөлөгчид шилжсэн тухай мэдэгдлийг томилогдсоноос хойш 24 цагийн дотор тухайн банкны эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх;

14.1.3. Тухайн банкны газар хэлтсийн захирал, салбар нэгжийн удирдлагын эрх, үүрэг, зардал гаргах эрх хэмжээг тогтоосон шийдвэр гаргаж мэдэгдэх;

14.1.4. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх өдрийн өмнөх өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, шүүх, шийдвэр гүйцэтгэлийн алба болон бусад хууль хяналтын байгууллагаар хянагдаж, оролцож байгаа хэргүүд болон бусад холбогдох тайлан мэдээг гаргуулан банкны гүйцэтгэх удирдлага, санхүү хариуцсан эрх бүхий албан тушаалтан, ажилтнаар гарын үсэг зуруулж, тамга тэмдгээр баталгаажуулан хүлээн авах;

14.1.5. Тусгай төлөөлөгчид туслах ажлын хэсгийг удирдлагаар хангаж, банкны тайлан тэнцэл, бичиг баримт, тэнцлийн гадуурх бүртгэлийг батлагдсан удирдамж, загварын дагуу гаргуулан авах (Энэ журмын хоёрдугаар хавсралт);

14.1.6. Банкны актив, пассивт хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр зохих стандарт, шаардлагын дагуу үнэлгээ хийлгэх зарыг нэн даруй тарааж, сонгон шалгаруулах ажлыг хийж, аль болох хурдан хугацаанд үнэлгээг хийлгэнэ;

14.1.7. Банкинд хөрөнгө оруулахыг банкны хувь нийлүүлэгч, нэгдлийн толгой компаниас шаардана. Хэрэв банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахаас өмнө энэ төрлийн шаардлагыг Монголбанкнаас тавьсан боловч хувь нийлүүлэгч, нэгдлийн толгой компани биелүүлээгүй бол дахин шаардахгүй байж болно;

14.1.8. Тусгай төлөөлөгч нь Банкны тухай хуулийн 69.1.14, 35.8-т заасны дагуу хувь нийлүүлэгчдэд алдагдлыг хүлээлгэж, тэдгээрийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгө, бусад сангаас хасалт хийж санхүүгийн тайланд тусгасны дагуу банкны дүрэмд зохих өөрчлөлтийг оруулан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ;

14.1.9. Тусгай төлөөлөгч нь Банкны үндсэн хөрөнгийн тооллогыг нэн даруй эхлүүлж биет байдлаар дутагдсан болон банкны өмчлөл, эзэмшлийн бус хөрөнгийг зохих этгээдээс нэхэмжлэх, дутагдлыг бүртгэж, холбогдох журмын дагуу эрсдэлийн санг байгуулна;

14.1.10. Хуульд заасан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

---

<sup>11</sup> БТХ-ийн 54.2 дахь заалт!!!

## **Арван тав. Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх**

- 15.1. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахаар шийдвэр гарсан тохиолдолд Монголбанкнаас томилсон ажлын хэсэг, Хадгаламжийн даатгалын корпораци, Тусгай төлөөлөгч хамтран энэ журмын 12.1-д заасан төлөвлөгөөнд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгаж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулна.
- 15.2. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг шинэчлэх саналыг боловсруулахдаа Монголбанкны хяналт шалгалт, бодит нөхцөл байдал, Банкны хяналт шалгалтын хорооны зөвлөмж, банкны актив, пассивыг Банкны тухай хуулийн 43.3 эсхүл 56.7 дахь хэсэгт заасны дагуу хийлгэсэн үнэлгээг үндэслэнэ. Активын чанарын үнэлгээ нь Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах шийдвэр гарахаас 6 сарын дотор хийгдсэн бол бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд ашиглаж болно<sup>12</sup>.
- 15.3. Тусгай төлөөлөгч нь актив, пассивыг үнэлэх этгээдийг сонгож үнэлгээг хийлгэнэ. Актив, пассивыг үнэлэх стандарт, шаардлага нь Монголбанк, Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрх зүйн акт байна.
- 15.4. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авахдаа Банкны тухай хуулийн 55.1 дэх хэсэгт заасан хэрэгслийг дангаар болон хослуулан сонгох хувилбаруудыг гаргаж, тэдгээрийн давуу болон сул тал, эдийн засгийн тооцоо, зардлын тооцоо, цаг хугацаа, шуурхай байдал, бусад нөлөөг хооронд нь харьцуулсан байна.
- 15.5. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг шинэчлэх саналыг боловсруулахдаа дараахь зарчмыг баримтлан, боломжит хувилбаруудыг хооронд нь харьцуулна:
  - 15.5.1. Харилцагч, хадгаламж эзэмшигч, зээлдүүлэгчийн эрх ашиг боломжит дээд хэмжээгээр хамгаалагдсан байх;
  - 15.5.2. Төрөөс зардал гаргах тохиолдолд хамгийн бага байх;
  - 15.5.3. Банкны системд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл бага байх;
  - 15.5.4. Хуульд заасан хугацаанд хэрэгжихүйц байх.
- 15.6. Монголбанк нь банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг шинэчлэх саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хянаж, батална.
- 15.7. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Банкны тухай хуулийн 55.1.3 дахь заалтад заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх арга хэмжээг тэргүүн ээлжинд харгалзан үзнэ.
- 15.8. Банкны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх арга хэмжээ авах тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчдийн албан ёсны хаягаар, шаардлагатай бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн авсан арга хэмжээний тухай мэдэгдлийг хүргүүлнэ. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны үнийг бууруулахдаа энэ журмын долоодугаар хавсралтад заасан аргачлалыг ашиглаж болно.

---

<sup>12</sup> Банкны тухай хуулийн 56.7-д Тусгай төлөөлөгч нь актив, пассивын үнэлгээг хийлгэх үүрэгтэй бөгөөд тусгай төлөөлөгч нь дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд цаг хугацаа хожих боломжийг олгох зорилгоор энэ арга хэмжээг зохион байгуулах нь зохимжтой гэж үзлээ.

- 15.9. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд Тусгай зориулалтын банк байгуулахаар шийдвэрлэсэн бол тухайн харилцаанд БТХ-ийн 20.4-д заасан журмыг баримтална<sup>13</sup>.
- 15.10. Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн бол тухайн харилцаанд Банкны тухай хуулийн 55.2-д заасныг баримтлах бөгөөд энэ журмын долоодугаар хавсралтад заасан аргачлалыг ашиглаж болно.
- 15.11. Тусгай төлөөлөгч нь бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь үр дүнгүй эсхүл хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл энэ тухайгаа Монголбанкинд зохих саналын хамт нэн даруй танилцуулна.
- 15.12. Тусгай төлөөлөгч нь Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө болон эрх, үүргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.

### **Арван зургаа. Хадгаламжийн даатгалын корпорацитай харилцах**

- 16.1. Банкны актив, пассив шилжүүлэх, Тусгай зориулалтын банк байгуулах хэрэгслийг ашиглахдаа Хадгаламжийн даатгалын корпорациас санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр бол Монголбанк, тусгай төлөөлөгч, Хадгаламжийн даатгалын корпораци хамтран ажиллана.
- 16.2. Тусгай төлөөлөгч томилох тохиолдолд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 17.5-д заасны дагуу нийгдсэн нөхөн төлбөрийн тооцоог Хадгаламжийн даатгалын корпораци гаргаж Монголбанкинд танилцуулна<sup>14</sup>.
- 16.3. Тусгай төлөөлөгчийн зөвлөлд Хадгаламжийн даатгалын корпорацийг төлөөлсөн гишүүнийг оролцуулах бөгөөд шаардлага хангасан этгээдийг томилуулахаар Монголбанкинд хүсэлтийг хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 16.4. Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 11.3-д заасан журмыг баримтална.

### **Арван долоо. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг дуусгавар болгох**

- 17.1. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанк дараахь үндэслэлээр дуусгавар болгоно:
- 17.1.1. Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах үндэслэл нь бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг шинэчлэн батлахаас өмнө банкны хэвийн үйл ажиллагаа хангагдсан;
- 17.1.2. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хэрэгслийг ашиглах шаардлагагүй болсон;
- 17.1.3. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө амжилттай хэрэгжсэн;
- 17.1.4. Батлагдсан бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө амжилттай хэрэгжих боломжгүй болсон;
- 17.1.5. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа дууссан.
- 17.2. Энэ журмын 17.1.1 болон банк дахин хөрөнгөжсөнөөс бусад үндэслэлээр дуусгавар болсон нөхцөлд Тусгай төлөөлөгч Банкны эрх хүлээн авагчид ажлаа хүлээлгэн өгнө. Банкнийг

<sup>13</sup> Банкны зөвшөөрлийн журамд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах шаардлагатай.

<sup>14</sup> Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 17.5 дахь заалтыг бичих

Банкны эрх хүлээн авагчид бүрэн шилжүүлэн өгөх хүртэл банкны актив хөрөнгө, үйл ажиллагааны хяналтыг тусгай төлөөлөгч бүрэн хариуцан ажиллана.

- 17.3. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ амжилттай хэрэгжсэн нөхцөлд банкны хувьцаа эзэмшигчид шилжүүлэх, бүтцийн өөрчлөлтийн үлдэгдэл актив, пассивыг Банкны эрх хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл Монголбанк Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 17.4. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг дуусгавар болгосон тохиолдолд тусгай төлөөлөгч нь бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэрэгсэл, зардлыг тусгасан ажлын тайланг Монголбанкинд хүргүүлэх бөгөөд үүнийг Монголбанк батална.
- 17.5. Тусгай төлөөлөгч нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээтэй холбоотой бичиг баримтыг архивын журмын дагуу бэлтгэж Монголбанкны архивт хүлээлгэн өгнө.
- 17.6. Тусгай төлөөлөгчийн болон зөвлөлийн гишүүдийг хэрэглэж байсан тамга, тэмдэг, дардас, лац, үнэмлэх, албан бичгийн маягт зэрэг банкны тусгай төлөөлөгч гэсэн албан ёсны тэмдэглэгээтэй эд зүйлсийг Монголбанкны нууцын албанд хүлээлгэн өгөх эсхүл баримтжуулан устгана.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **БАНКИЙГ ТАТАН БУУЛГАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

#### **Арван найм. Банкнийг татан буулгах үндэслэл, банкны эрх хүлээн авагчийг томилох**

- 18.1. Монголбанк дараахь үндэслэлээр банкнийг татан буулгах шийдвэр гаргаж, банкны эрх хүлээн авагч томилно:
- 18.1.1. Монголбанкнаас албадлагын арга хэмжээний хүрээнд банк байгуулах тусгай зөвшөөрлийг цуцалсан<sup>15</sup> шийдвэрийг гаргасан;
- 18.1.2. Монголбанкнаас энэ журмын 17.2-д заасан үндэслэлээр;
- 18.2. Банкнийг татан буулгах тухай Монголбанкны шийдвэрт дор дурдсан зүйлсийг тусгана:
- 18.2.1. Банкны эрх хүлээн авагч томилогдсон банк, түүний нэгжийн нэр, оршин байгаа газар, хаяг;
- 18.2.2. Банкнийг татан буулгах арга хэмжээ авах үндэслэл, шалтгаан;
- 18.2.3. Орлон ажиллах этгээдийг томилох,
- 18.2.4. Банкнийг татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх болон Банкны эрх хүлээн авагчийн үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа;
- 18.2.5. Банкны эрх хүлээн авагчийн овог нэр, түүнд туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүн.
- 18.3. Банкнийг татан буулгах шийдвэр гарснаар банк, түүний удирдлагын бүрэн эрх болон хөрөнгийг захиран зарцуулах эрх Банкны эрх хүлээн авагчид шилжинэ.

<sup>15</sup> БТХ-ийн 27.1.6

18.4. Монголбанк нь банкиг татан буулгах тухай шийдвэр гаргаснаас хойш 24 цагийн дотор, татан буугдаж байгаа банк, түүний удирдлага, хяналтын эрх Банкны эрх хүлээн авагчид шилжсэн тухай зарлал (энэ журмын наймдугаар хавсралтад заасан загвар), мэдээллийг олон нийтэд мэдээлэх арга хэмжээг зохион байгуулж, тухайн банк, түүний бүх нэгжийн байранд байршуулна.

**Арван ес. Банкны эрх хүлээн авагчийн бүрэн эрх, үүрэг,  
банкийг татан буулгах арга хэмжээ хэрэгжих нөхцөл**

19.1. Банкныг албадан татан буулгах шийдвэр гарсан өдрөөр тасалбар болгон Банкны гүйцэтгээгүй мөнгөн төлбөрийн үүрэгт хүү, алданги, торгууль тооцохыг зогсоох шийдвэр гаргаж хадгаламж эзэмшигч, зээлдүүлэгч, банкнаас авлагатай бусад этгээдэд мэдэгдэнэ<sup>16</sup>.

19.2. Банкны эрх хүлээн авагч нь Банкны тухай хуулийн 69.1 дэх хэсэгт заасан эрхийг эдэлж, дараах үүргийн хүлээнэ:

19.2.1. Зээлдэгчийн судалгааг нэг бүрчлэн гаргаж, хэрвээ тухайн хадгаламж эзэмшигч, харилцагчид тухайн банкинд зээл, хүүгийн өртэй бол банкнаас тэдгээр хадгаламж эзэмшигч, харилцагчид өгөх өр төлбөрөөс уг зээл болон бусад авлагыг суутгах арга хэмжээ авна.

19.2.2. Банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай хуулийн 15.5-д заасны дагуу даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой бэлтгэл ажлыг Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран зохион байгуулах, шаардлагатай мэдээллээр хангах;

19.2.3. Банкны активыг төлүүлэх:

19.2.3.1. Зээл, авлагыг барагдуулах;

19.2.3.2. Хөрөнгө худалдан борлуулах;

19.2.3.3. Шүүхэд нэхэмжлэл гаргах;

19.2.3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах.

19.2.4. Нэхэмжлэлийг хүлээн авах;

19.2.4.1. Банкны эрх хүлээн авагч нь Банкныг татан буулгах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 2 сарын дотор банкнаас үүргийн гүйцэтгэл шаардах эрх бүхий этгээдээс нэхэмжлэл хүлээн авах тухай мэдэгдлийг есдүгээр хавсралтад заасан загварын дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. Олон нийтэд мэдээлсэн нь нэхэмжлэлийн шаардлага гаргах бүх этгээдэд мэдэгдсэнтэй адил тооцогдоно<sup>17</sup>;

19.2.4.2. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр нь энэ журмын есдүгээр хавсралтад заасан загварын шаардлагыг хангасан байна.

19.2.5. Нэхэмжлэлийг баталгаажуулах:

19.2.5.1. Нэхэмжлэл хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш 90 хоногийн дотор Банкны тухай хуулийн 71.2-д заасны дагуу банкны эрх хүлээн авагч төлбөр барагдуулах дарааллыг тогтоож, нэхэмжлэлийн шаардлага болон түүний баталгаажсан хэмжээний талаар нэхэмжлэгч этгээдэд мэдэгдэнэ;

<sup>16</sup> БТХ-ийн 69.1.10 дахь заалтаас зайлсхийнэ !!!

<sup>17</sup> БТХ-ийн 71.1-д бүх этгээдэд нэгбүрчлэн мэдэгдэх гэж ойлгогдож байгаа.



- 19.2.5.2. Хүлээн авсан нэхэмжлэлийг баталгаажуулахдаа Банкны тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан нөхцөлүүдийг харгалзан үзнэ.
- 19.2.5.3. Нэхэмжлэлийг хүлээн авах 60 хоногт багтаан ирүүлээгүй нэхэмжлэлийг Банкны тухай хуулийн 71.3-т заасны дагуу хүлээн авахаас татгалзаж, нэхэмжлэлийн дараалалд оруулахгүй бөгөөд нэхэмжлэлийг хангахгүй.
- 19.2.5.4. Банкны эрх хүлээн авагч нь ирүүлсэн нэхэмжлэлийн үнэн зөвийг БТХ-ийн 71.2.1, 71.2.2-т заасны дагуу шалгаж, үндэслэлгүй гэж үзэх эсхүл нэхэмжлэлийг шаардлагаас татгалзаж буй хэмжээг тодорхойлно.
- 19.2.6. Татан буулгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлах;
- 19.2.7. Татан буулгах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу нэхэмжлэгчдийн өр төлбөрийг барагдуулж, орлогыг хуваарилах;
- 19.2.8. Шаардлагатай тохиолдолд Банкны хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр зохих стандарт, шаардлагын дагуу хийлгэх бөгөөд тусгай төлөөлөгчийн хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр хийлгэсэн хөрөнгийн үнэлгээг ашиглаж болно;
- 19.2.9. Энэ журмын 19.2.7-д заасан хөрөнгийн үнэлгээнд үндэслэн нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах замаар хөрөнгө, шаардах эрхийг түргэн шуурхай худалдан борлуулах арга хэмжээ авна;
- 19.2.10. Нээлттэй дуудлага худалдааг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлж болно.
- 19.3. Банкны эрх хүлээн авагч нь банкиг татан буулгах ажиллагаатай холбоотой доорх мэдээллийг Монголбанкнаас тогтоосон хугацаанд дэлгэрэнгүй тайлан хэлбэрээр тогтмол хүргүүлнэ:
- 19.3.1. Төлөгдсөн зээл, авлага;
- 19.3.2. Худалдан борлуулсан хөрөнгө;
- 19.3.3. Нэхэмжлэлийн дарааллын дагуу барагдуулсан өр төлбөр;
- 19.3.4. Санхүүгийн тайлан;
- 19.3.5. Шүүх, хяналтын байгууллагатай холбоотой хэргийн мэдээ;
- 19.3.6. Бусад.
- 19.4. Банкны эрх хүлээн авагч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авах үүргийн дараахь байдлаар хэрэгжүүлнэ:
- 19.4.1. Харуул, хамгаалалтыг бэхжүүлэх, хяналтын камер дохиоллыг нэмэгдүүлэх;
- 19.4.2. Архивын стандартын шаардлагыг хангуулах;
- 19.4.3. Эд хариуцагч тогтоох;
- 19.4.4. Тооллого хийж, хөрөнгийн чанарыг хадгалах арга хэмжээ авах;
- 19.4.5. Бусад шаардлагатай арга хэмжээ.
- 19.5. Банкны эрх хүлээн авагч нь Банкны тухай хуулийн 69.4-д заасан баримт, материалыг томилогдсон өдрөөс хойш 60 хоногийн дотор дараахь нэмэлт баримтын хамт Монголбанкинд хүргүүлнэ:

19.5.1. Банкны эрх хүлээн авагчийн болон Банкны эрх хүлээн авагчид туслах ажлын хэсгийн гаргасан тайлангийн дагуу хийгдсэн тохируулгын гүйлгээний жагсаалт, түүний дараахь санхүүгийн тайлан;

19.5.2. Зээлийн хувийн хэрэг, барьцаа хөрөнгийн талаарх тайлан, мэдээ;

19.5.3. Архивын жагсаалт, хүний нөөц, бичиг хэргийн талаарх мэдээ;

19.5.4. Бусад.

19.6. Банкны эрх хүлээн авагч нь Банкнийг татан буулгах арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд хүргүүлнэ.

#### **Хорь. Хадгаламжийн даатгалын корпорацитай харилцах**

20.1. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 21.1.4 дэх заалтын дагуу Хадгаламжийн даатгалын корпораци нь Банкны эрх хүлээн авагчийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрийн төлөөллийг оролцуулах хүсэлтийг Монголбанкинд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

20.2. Банкны эрх хүлээн авагч нь даатгалын тохиолдол бий болсон өдрөөр тасалбар болгон Хадгаламжийн даатгалын корпорацид банкны хадгаламжийн болон бусад холбогдох шаардлагатай мэдээллээр хангана.

20.3. Банкны эрх хүлээн авагч нь Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу даатгалд үл хамаарах хадгаламж болон даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг дахин тооцож, хянаж баталгаажуулна.

20.4. Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооноос баталсан “Гомдол хүлээн авах, шийдвэрлэх заавар”-ын дагуу хамтран ажиллана.

#### **Хорин нэг. Төлбөр барагдуулах дараалал**

21.1. Банкны зээл, авлага, активыг төлүүлсэн, худалдаж борлуулсны орлогоос нэхэмжлэгчдийн шаардлагыг хангахдаа Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт заасан дарааллыг баримтална.

21.2. Банкны эрх хүлээн авагч нь Банкны тухай хуулийн 69.1.1, 69.1.3-д заасны дагуу банкны өрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүнд тэнцэх хэмжээний актив хөрөнгийн хамт гэрээний дагуу шилжүүлэхдээ Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлд заасан дарааллыг баримтална.

#### **Хорин хоёр. Банкны эрх хүлээн авах арга хэмжээ дуусгавар болгох**

22.1. Банкны эрх хүлээн авагч нь дараахь тохиолдолд банкнийг татан буулгах ажиллагааны тайланг Монголбанкинд хүргүүлнэ:

22.1.1. Нэхэмжлэлийн шаардлагыг хангах Монголбанкнаас баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд тодорхойлсон актив хөрөнгө үлдээгүй;

22.1.2. Нэхэмжлэлийн шаардлагыг барагдуулж дууссан.

22.2. Монголбанк банкны тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу татан буулгах арга хэмжээг дуусгавар болгоно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

## ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, ТАЙЛАГНАЛ

### Хорин гурав. Хяналт, хариуцлага, тайлагнал

- 23.1. Монголбанк нь энэ журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, журмын заалтыг зөрчсөн этгээдэд Банкны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 23.2. Энэ журмын 3, 4, 5 дугаар зүйлд заасан арга хэмжээний хэрэгжилтэд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан БЭТ, ТТ, БЭХА-г удирдлагаар хангах эрх бүхий ажлын хэсэг, Банкны хяналт шалгалтын хороо хяналт тавина.
- 23.3. БЭТ, ТТ, БЭХА нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирлыг хариуцах бөгөөд банкны үйл ажиллагааны ердийн эрсдэлд хамруулж болох хохирол учирсан нь БЭТ, ТТ, БЭХА-д хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.
- 23.4. Монголбанкнаас банкуудад авсан урьдчилан сэргийлэх албадлагын арга хэмжээний хүрээнд авсан тайланг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд жил тутам мэдээлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

## **Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулах аргачлал**

### **Агуулга:**

Нэг.	Банкны тухай танилцуулга
Хоёр.	Монголбанкнаас авсан арга хэмжээ, түүний үр дүн
Гурав.	Банкны санхүү, төлбөрийн чадварын нөхцөл байдал, эрсдэлийг тодорхойлсон төсөөлөл, системд учруулж болзошгүй сөрөг нөлөө
Дөрөв.	Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх санал
Тав.	Хавсралт

Тусгай төлөөлөгч нь бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг Монголбанкнаас гаргасан шийдвэрт үндэслэн банкны цар хүрээ, системд эзлэх байр суурь, санхүү төлбөрийн чадварын нөхцөл байдал, харилцагчийн суурь, өөрийн хөрөнгө, хувь нийлүүлэгчдийн бүтэц, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн хуульд заасан бүтцийн өөрчлөлтийн хэрэгслүүдийг ашиглахаар боловсруулна.

Тусгай төлөөлөгч нь бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулахаас өмнө актив, пассивын үнэлгээг хийлгэснээр банкны актив, пассив, өөрийн хөрөнгийн дүнг тодорхой болгоно.

Тухайн нөхцөл байдал, банк тус бүрийн онцлогоос хамаарч төлөвлөгөөг өөрчилж болох бөгөөд дараахь асуудлуудыг хамруулсан байх шаардлагатай.

### **Нэг. Банкны тухай:**

Тухайн банкны үйл ажиллагааны хамрах цар хүрээ, товч түүх, бизнесийн загвар, зах зээлд эзлэх хувь, хувь нийлүүлэгчийн бүтэц, удирдлага зохион байгуулалт, салбар нэгж, хүний нөөц, технологи, мэдээллийн технологийн түвшин, онцлог, давуу болон сул тал зэргийг тусгасан товч, тодорхой мэдээллийг багтаана. Эдгээр мэдээлэл нь бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөтэй танилцах этгээдүүдэд шийдвэр гаргахад нь туслах ерөнхий мэдээлэл бөгөөд бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний хувилбар гаргасан нөхцлийн мэдээллийн суурь үндэслэл болох шаардлагатай.

**Зах зээлд эзлэх хувь, хүний нөөц, салбар нэгж, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны хамрах цар хүрээ:** Салбар нэгжийн тоо, тархалт, харилцагчийн суурь, үйлчилгээний төрөл, тархалт зэргээр олон нийтэд үйлчилгээ нь хэр зэрэг нэвтэрсэн, зах зээлийн хэдий хэр хувийг эзэлсэн, зах зээлд ямар нөлөөтэй (системийн ач холбогдолтой эсэх) болох, хүний нөөцийн тоо болон чанар, чадварыг товч тодорхойгоор тоон үзүүлэлтийг хамруулна. Бүтэц зохион байгуулалтын зураглал зэрэг шаардлагатай чухал мэдээллүүдийг хавсаргана.

**Товч түүх:** Банкны үүсгэн байгуулагдсанаас хойшхи гол өөрчлөлт, өмчийн хэлбэр, бүтэц, хувьцааны гол шилжилтийг агуулсан товч түүх.

**Хувь нийлүүлэгч:** Банкны толгой компани, эцсийн өмчлөгч, удирдлага, бүтэц зохион байгуулалтыг товч танилцуулах. Банкны нэгдлийн бүтэц, оролцоо, холбогдох актив, пассив, гэрээ хэлцлийн жагсаалтыг хавсаргах.

**Технологи, мэдээллийн технологи:** Тухайн банкны мэдээллийн технологийн онцлог, эрсдэл, давуу, сул тал, нууцлал, аюулгүй байдал, төлбөр тооцооны эрсдэл зэрэг гол мэдээллүүд.

Бусад шаардлагатай гэж үзсэн мэдээллүүд.

### **Хоёр. Монголбанкнаас авсан арга хэмжээ, түүний үр дүн:**

Монголбанкнаас тухайн банкны санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ, түүний үр дүнг товч, тодорхой дурдана. Шаардлагатай тоо, баримт, үзүүлэлтийг аль болох хүснэгт, график, схемээр дараахь төрлүүдээр гаргана:

- Монголбанкнаас тухайн банкинд авсан урьдчилан сэргийлэх болон тогтворжуулалтын төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээ, түүний үр дүн. Шаардлагатай бол цаг хугацааны дарааллаар авсан арга хэмжээ, түүний нөлөө, зохистой харьцааны үзүүлэлтийг хавсралтаар үзүүлнэ;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран тухайн банкны санхүү, төлбөрийн чадварыг сайжруулахаар гаргасан бусад тушаал, шийдвэр, хэрэгжилт;
- Хэрэв нөхцөлт удирдлагын арга хэмжээ авч, бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон боловч банкны хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй бол Бүрэн эрхт төлөөлөгчийн тайланд тусгагдсан хураангуй товчоон буюу дүгнэлтийг оруулах;
- Банкнаас гаргасан бизнес төлөвлөгөө, өөрийн хөрөнгийн төлөвлөгөө, чанаргүй активыг бууруулах стратеги зэрэг нь хэрхэн хэрэгжсэнийг Монголбанкнаас шалгасан тухай товч танилцуулга;
- Монголбанкны бүх төрлийн шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээ, арга хэмжээний тухай саналууд, түүнийг шийдвэрлэсэн байдал, үр дүн;
- Бусад.

### **Гурав. Банкны санхүү, төлбөрийн чадварын нөхцөл байдал:**

Банкны системд эзлэх хувь, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, даатгагдсан хадгаламж, хүний нөөц, салбар нэгжийн тархалт зэрэг гол үзүүлэлтийг товч хүснэгт, графикаар гаргаж нэг хуудсанд багтаан танилцуулга гаргана.

Нэг хуудас танилцуулгаас шаардлагатайг нь дэлгэрэнгүй байдлаар чанарын хүчин зүйлсийг түлхүү үзүүлсэн байдлаар танилцуулна. Голчлон үзүүлэх мэдээллийн багцыг дор дурьдвал:

- Актив, пассивын үнэлгээний тайлангийн дүгнэлт, санхүүгийн тайланд тусгагдах гол өөрчлөлт, тохируулга;
- Тэнцлийн бүтэц, гол төвлөрөл;
- Төлбөрийн чадвар болон хөрвөх чадварын байдал;
- Банк, санхүүгийн системд эзлэх оролцоо, системд учруулж болзошгүй сөрөг нөлөө;

- Санхүү, төлбөрийн чадварын хүндрэл нөлөөлсөн хүчин зүйл, үйл ажиллагаа, актив, өр төлбөрийн үүрэг;
- Холбогдох этгээдийн болон хамааралтай этгээдийн зээл, актив, хүлээж болзошгүй үүрэг, түүний чанар;
- Даатгагдсан болон даатгалд хамрагдахгүй хадгаламж, өр төлбөрийн мэдээ;
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт, бүтэц, дутагдлын хэмжээ;
- Активаар төлөгдөх боломжгүй пассив байгаа эсэх, хэрэв байгаа бол тэдгээрийн хохирлын тооцоо, таамаглал;
- Шүүх, хяналтын байгууллагаар шийдвэрлэгдээгүй байгаа буюу маргаантай, гэмт хэргийн шинжтэй актив, пассив, хүлээж болзошгүй үүрэг зэрэг нь банкны өөрийн хөрөнгийн дутагдалд материаллаг хэмжээгээр нөлөөлж байгаа болон нөлөөлж болзошгүй бол тэдгээр хэрэг, маргааны тухай нэгдсэн мэдээ.

Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах шийдвэрийн дагуу Тусгай төлөөлөгч томилогдсон өдрийн буюу өмнөх өдрийн аль нэгээр тасалбар болгосон байдлаар банкны удирдлагаас санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар хэдэн хуудас, ямар тайлангуудаар хүлээн авсан тухай бичнэ.

Тусгай төлөөлөгчид туслах ажлын хэсгийн ажилласан тухай товч, шаардлагатай зүйлсийг дэлгэрэнгүй бичнэ.

Тусгай төлөөлөгч нь хүлээн авсан тайланг шалган үзэж, актив хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг тоолж шалган зохих **тохируулга хийж санхүүгийн тайланд** тусгасны дараа дараахь чиглэлээр танилцуулна.

**Өөрийн хөрөнгө:** Банкны өөрийн хөрөнгийн дүн, зохистой харьцааны үзүүлэлт, өөрийн хөрөнгийн дутагдал, банкны актив хөрөнгө нь өр төлбөрийн хэмжээнээс давсан эсэх, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг ханган ажиллахад шаардлагатай дахин хөрөнгөжүүлэлт буюу нэмэлт **шаардлагатай өөрийн хөрөнгийн дүнг тодорхой гаргах.**

**Активын чанар:** Банкны чанаргүй активын дүн, хувь хэмжээг бичих. Холбогдох этгээдийн болон хувь нийлүүлэгчийн шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг, удирдлага, үйл ажиллагааны хувьд хамааралтай, удирдлага, хяналтандаа байлгадаг компаниудаараа дамжуулан авсан зээл, активын дүнг тодорхой бичих. Банкны санхүү, төлбөрийн чадвар муудахад нөлөөлсөн гол активыг дурдана.

**Өр төлбөр:** Банкны даатгагдсан хадгаламжийн хэмжээ, тоо нь нийт өр төлбөрийн хэдий хэмжээг эзлэх, даатгаагүй хадгаламж, өр төлбөрийн хэдэн хувийг үлдсэн актив хөрөнгөөр барагдуулах боломжтойг төсөөлж, тооцно. Өр төлбөрөөс хэр ихийг бусад банкинд актив, пассив шилжүүлэх (P&A) замаар шийдвэрлэх, үлдсэн өр төлбөрийг хэрхэн барагдуулах дараалал, барагдуулж чадахгүй байх нөхцлийг тооцно.

**Үүссэн гол эрдсэл:** Банкнийг хүндрэлд оруулсан хүчин зүйлс нь түр зуурын буюу засах боломжтой, эсхүл ноцтой бөгөөд санхүү, төлбөрийн чадварыг урт хугацаанд сөргөөр нөлөөлсөөр байх, дахин нөхөгдөхгүй байх эсэх хандлагыг тодорхойлно.

**Системийн нөлөө:** Банк, санхүүгийн системд эзлэх оролцоо, нөлөө нь хэр зэрэг их, харилцан хамааралтайг тодорхойлно. Тухайн банкны эрдсэл нь шууд болон шууд бусаар бусад банк, санхүүгийн байгууллагад сөрөг нөлөө үзүүлэх эсэх, үндсэн бизнес, зах зээлд эхлэх хувь, чанартай болон чанаргүй активын хэмжээ, ялгаа, харилцагчийн суурь, пассивын бүтэц зэргийг дараахь үзүүлэлтээр тодорхойлно:

- Олон нийтэд үйлчилгээ нь нэвтэрсэн хувь, зах зээлийн хувь;
- Үндсэн суурь бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, тархалт;
- Зах зээлд эзлэх байр суурь;
- Банкны салбар, нэгжийн сүлжээ;
- Хүний нөөцийн чадавхи;
- Техникийн болон үйл ажиллагааны технологи;
- Тухайн банк системээс гарвал, системд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.

### **Дөрөв. Банкны Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх санал:**

- Хууль, эрх зүйн үндэслэл.
- Банкинд бүтцийн өөрчлөлтийн хэрэгслийг хэрэглэх арга хэмжээний сонголт, хувилбар.
- Өр төлбөр, үүргийн нөхцөл:
  - Даатгагдсан хадгаламжийн дүн, хадгаламж эзэмшигчдийн тоо, бүрэн болон хэсэгчлэн даатгагдсан мэдээлэл;
  - Даатгалын тохиолдлоос хасагдах хадгаламжийн мэдээлэл, тайлбар;
  - Даатгагдаагүй хадгаламжийн мэдээлэл;
  - Даатгагдаагүй бусад өр төлбөрийн мэдээлэл.
- Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх хамгийн оновчит хувилбарын санал.
  - Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахдаа Банкны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасан хэрэгслүүдийг дангаар нь буюу хослуулан сонгох хувилбаруудыг гаргаж, тэдгээрийн давуу болон сул тал, эдийн засгийн тооцоо, цаг хугацаа, шуурхай байдал болон бусад нөлөөг хооронд нь харьцуулна.

Хувилбар тус бүрт зардлын тооцоог гаргаж, хамгийн бага зардлын хувилбар (least cost analyse) болон нийгэм, эдийн засаг, банкны системд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг тооцож боловсруулна.

Монголбанкнаас Банкны тухай хуулийн 47.5-д заасны дагуу Тусгай төлөөлөгчийн хэрэгжүүлэх БӨТ-г боловсруулах ажилд ТТ-тэй хамтран ажиллаж төлөвлөгөөг боловсруулах багыг тодорхой хугацаагаар томилж ажиллуулна.<sup>18</sup>

ТТ нь Банкны тухай хуулийн 56.7-д заасан ёсоор банкны актив, пассивын үнэлгээг хийлгэсний дараагаар БӨТ-г уг үнэлгээг үндэслэн боловсруулна.

Хувилбаруудаас аль нь хамгийн оновчтой (зардал уу? хадгаламж эзэмшигч, банкнаас авлагатай этгээдүүдийн эрх ашиг уу? банкны систем үү? төрөөс гарах санхүүжилт, хөрөнгө оруулалт уу?) гэж үзсэн хувилбарыг Монголбанкинд санал болгоно.

БӨТ-ний хувилбар нь дараахь төрөл (тухайн нөхцөл байдлаас хамаарч бусад холимог болон онцгой хувилбарууд үүсч болно)-тэй байж болно:

<sup>18</sup> Банкны тухай хуулийн 47.5. Монголбанк банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулж, батална гэж заасан тул энэ заалтыг оруулав

- **Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулж (dilution), шинээр хөрөнгө оруулагч татах.**
  - Банкны хувь нийлүүлэгчид нь шаардлагатай нэмэлт өөрийн хөрөнгөө оруулж чадахгүй тохиолдолд ТТ нь хувьцааны нэрлэсэн үнийг бууруулж, банкны алдагдлыг хувь нийлүүлэгчдэд хүлээлгэнэ. Шаардлагатай нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээгээр шинээр хувьцаа гаргаж хувь нийлүүлсэн хөрөнгийг бусад этгээдээс хөрөнгө татах замаар банкныг дахин хөрөнгөжүүлэх.
  
- **Банкны актив, пассивыг шилжүүлэх (Purchase and Assumption: P&A )**
  - Бусад банкуудад бүтцийн өөрчлөлтийн хувилбараа тодорхой саналтайгаар танилцуулж тухайн банкинд хөрөнгө оруулах, актив пассивыг шилжүүлж авах эсэх тухай тодорхой хариу саналыг авах. Тусгай төлөөлөгч нь банкны актив, пассив болон бусад мэдээллийг багтаасан багц танилцуулга (АППШ багц мэдээлэл) бэлдсэн байх шаардлагатай. Төрлүүд нь дараахь хэлбэрүүдтэй байх боломжтой:
    - Банкны **нийт актив**, пассивыг шилжүүлэх (Whole P&A): Нийт актив, пассивыг үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа банкинд багцалж шилжүүлэх. Пассивыг бүхэлд нь буюу нийт дүнгээр нь нэрлэсэн үнээр, активыг үнэлгээчний үнэлсэн үнийн дүнгээр (чанаргүй активыг үнэлсэн дүн 0 бол?). Чанаргүй активыг үнэлгээчний үнэлсэн дүнгээр шилжүүлснээр актив, пассив үлдэхгүй хувилбар.
    - **Сайн активыг**, пассивын хамт шилжүүлэх (Good/bad asset -P&A): Сайн активыг, нийт пассивын хамт үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа банкинд багцалж шилжүүлэх.
      - Сайн активыг хүлээн авах банк сонгоно. Чанаргүй активыг ТТ-чид үлдээх буюу банкныг татан буулгах шийдвэр МБЕ гаргасан тохиолдолд Банкны хүлээн авагчид шилжүүлэх эсхүл үнэлсэн дүнгээр АУК-д шилжүүлэх, бусдад худалдах зэргээр шийдэх,
      - Пассиваас бүхэлд нь буюу нийт дүнгээр нь нэрлэсэн үнээр, сайн активыг үнэлгээчний үнэлсэн дүнгээр,
    - **Актив, пассивыг хэсэг хэсгээр нь задалж шилжүүлэх (Partial P&A):**
      - Актив, пассивыг задалж олон банк, санхүүгийн байгууллагад шилжүүлэх замаар бүх актив пассивыг дуусгах. Өөрийн хөрөнгө бүрэн хорогдож дуусаагүй үед энэ хувилбар үр дүнтэй. хэрэв өөрийн хөрөнгө бүрэн хорогдож дуусахаар нөхцөл үүсвэл ТТ нь банкныг татан буулгах саналаа МБЕ-д яаралтай гаргаж БЭХА томилох, банкны дампуурлыг зарлах зэрэг хувилбар
      - шаардлагатай болно.
  
- **Зарим активыг, пассивын хамт шилжүүлэх (sectional P&A)**
  - Зарим актив буюу банкны хэвийн активаас банк, банк бус, ХЗХ, АУК зэрэг боломжит худалдан авагчдад өөрсдийн сонголтоор актив авах дуудлага худалдаа явуулах замаар банкны актив хөрөнгийг бүхий л талаар активыг үнэд хүргэх арга хэмжээг авна.



- активыг сонгож авсан этгээд нь банкны пассиваас авахаар сонгосон активын хэмжээнд хүртэл өөрсдийн сонголтоор пассивыг шилжүүлэн авах сонголтыг хийнэ.
- хэрэв авахаар шийдсэн актив нь пассиваас их бол зөрүүг шилжүүлэн авагч (acquirer or assuming party) нь пассиваас давсан активыг мөнгөн хөрөнгөөр төлөх буюу зээлээр төлөх нөхцлийг гэрээний дагуу ТТ-тэй тохиролцоно.
- Олон санал ирсэн бол актив, пассивыг дуудлага худалдаанд оруулах,

### **Багц танилцуулга (АПШ багц мэдээлэл) (infomation package for P&A)**

АПШ багц мэдээлэл, танилцуулгад орох мэдээлэл нь хамгийн багадаа дараахь мэдээллийг агуулна:

- Тэнцэл;
- орлогын тайлан;
- санхүүгийн тайлан, мэдээ;
- эрсдэл үүсгэсэн гол үйл ажиллагаа, активын талаарх тусгайлсан мэдээлэл;
- активын гол эрсдэл;
- актив, пассивын үнэлгээний тайлан;
- даатгагдсан хадгаламжийн мэдээ;
- Шүүх, хяналтын байгууллагад байгаа бүх мэдээлэл;
- Бусад шаардлагатай мэдээлэл.

АПШ тохиролцооны санал авах нь маш богино хугацаанд байх шаардлагатайгаас гадна нууцлал өндөртэй байх, сонирхогч этгээд нь актив, пассивын талаар мэдээлэл, бичиг баримтусгай төлөөлөгчэй танилцах боломжтой байх шаардлагатай. Ихэнхи тохиолдолд эрсдэл үүсгэж болзошгүй активыг тодорхой хугацаанд хяналт шалгалт (due diligence) хийсний дараа буцаан ТТ-д шилжүүлэх талаар гэрээнд тусган шууд шилжүүлэх нь банкны пассив гадагшлах, олон нийтийн итгэлийг бууруулахгүй байх давуу талтай.

- **Тусгай зориулалтын банк** (цаашид “Тусгай зориулалтын банк ” гэх) **байгуулах (Bridge bank);**
  - ТТ нь банкны актив пассивыг хэсэгчлэн болон задалж шилжүүлсний дараа үлдэх хэсгээр ТзБ байгуулж болно.
  - Тусгай зориулалтын банкиг төрийн оролцоотой буюу 100% төрийн өмчийн хэлбэртэй байгуулж болно.
  - Тусгай зориулалтын банк -ны өөрийн хөрөнгийг тогтворжуулалтын сангаас бүрдүүлэх эсэхийг БӨТ-нд тусгана.
  - Актив, пассивыг Тусгай зориулалтын банк -нд багцалж шилжүүлэх, чанаргүй актив үлдвэл БЭХА томилж банкиг татан буулгах буюу АУК-д шилжүүлэх, бусдад худалдах зэргээр шийдэх,

- ТТ нь Тусгай зориулалтын банк байгуулахдаа зөвхөн үүсгэн байгуулагчийн санаачлагч байж Тусгай зориулалтын банк -ийг үүсгэн байгуулах бичиг баримтыг Монголбанкнаас гаргасан зохицуулалтын хүрээнд байгуулж төрийн өмчийг төлөөлөх этгээдэд хүлээлгэн өгөх хүртэл тус банкыг Тусгай төлөөлөгчийн эрх үүргийн хүрээнд гүйцэтгэнэ.
- Тусгай зориулалтын банк байгуулахдаа шинээр байгуулах нь илүү зохимжтой. Хэрэв албадлагын арга хэмжээ авагдаж байгаа банкыг өөрчлөн байгуулах хэлбэрээр Тусгай зориулалтын банк -г үүсгэн байгуулахаар бол тэнцлийн дотуур, тэнцлийн гадуур болон бүртгэлгүй үүрэг байгаа эсэхийг сайтар нягталж, олон нийтэд зарлаж банкинд үүрэг ногдуулсан хэлцлүүдийг бүгдийг бүртгэж, танилцаж хянасаны үндсэн дээр Тусгай зориулалтын банк -г аливаа хэлбэрээр хожим үүрэг ногдохоор хэлцлүүдээс хамгаалах шаардлагатай.
- ТзБ нь төрийн өмчит хэлбэрээр байгуулагдах тул банкыг Банкны тухай хуулийн дагуу 3 хүртэлх жилийн бизнес төлөвлөгөө, өөрийн хөрөнгийн төлөвлөгөөний хамт гаргаж Монголбанк, ЗГ-т танилцуулахын зэрэгцээ ЗГ-аас хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалтад оруулна.
- Тусгай төлөөлөгчийн эрх, үүрэг, ажиллах хугацаа нь Тусгай зориулалтын банк -ийг хувь нийлүүлэгчээс томилсон банкны удирдлагад банкыг шилжүүлж өгөх, шаардлагатай тохиолдолд үлдэх хэсгийн БЭХА, АУК зэрэгт шилжүүлж өгснөөр дуусгавар болно.
- Төрөөс дахин хөрөгжүүлбэл банкны дахин хөрөнгөжүүлэлтийн хуулийн дагуу явуулна.
- ХДК-ийн хуулийн дагуу Тусгай зориулалтын банк -ны хувьцаанд хөрөнгө оруулж хувь нийлүүлэгчийн эрхийг хуулийн хүрээд хэрэгжүүлж буцаан хувьчлах хэлбэрээр ХДК-ийн сангаас оруулсан хөрөнгө оруулалтыг яаралтай нөхөн олж авахыг эрхэмлэнэ.
- ТТ нь банкны Банкны тухай хуулийн 55.1.3-аас бусад хэлбэрээр БӨТ-г боловсруулах Банкны тухай хуулийн 56.7-д заасны дагуу хийсэн үнэлгээний тайланг үндэслэнэ.
- **Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх**
  - ТУСГАЙ ТӨЛӨӨЛӨГЧ нь банкыг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл Банкны тухай хуулийн 59.2, 57.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор банкны өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлж болно.
  - Энэ журмын 9.1-д заасан хөрвүүлэлтэд Банкны тухай хуулийн 60.2-т дурдсан өр хамруулахгүй.
  - Зээлдүүлэгч болон бусад харилцагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэхдээ хувьцаа авах тухайн зээлдүүлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авсан байна.
  - Хувьцаанд хөрвүүлэх өр, төлбөр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл нь банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг байх бөгөөд үүнийг тусгай төлөөлөгч БӨТ-ний хамт боловсруулж, Монголбанкнаар батлуулсан байна.
  - Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх тухай төсөлд хувьцаагаар солих өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, банкны дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг тусгана.
  - Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэхдээ хувьцаа авах тухайн зээлдүүлэгч, харилцагч нь банкны хувьцаа эзэмшигчид Монголбанкнаас тавигдах шаардлагыг хангасан байх бөгөөд банкны хувьцаа эзэмшигч болох үйл ажиллагаанд Монголбанкнаас мөрдүүлэх холбогдох журмыг баримтлана.

- Банк нь хувьцаат компани бол СЗХ-оос зохих зөвшөөрлийг авсны үндсэн дээр өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлнэ.
- Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэхээр нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхтэй.

Бүтцийн өөрчлөлт хийхдээ тухайн банкинд хөрөнгө оруулах нөхцлийг судлах, санал авах.

Банкийг дахин хөрөнгөжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг хувь нийлүүлэгчдийн зүгээс оруулах **боломжтой эсэхээ** мэдэгдсэн албан бичиг авсан байна.

Банкийг дахин хөрөнгөжүүлэх хөрөнгө оруулагчийг олж хөрөнгө оруулах хүртэл Тусгай төлөөлөгчийн хяналтад банкны үйл ажиллагаа үргэлжлэх нь олон нийтийн итгэлийг сулруулахын зэрэгцээ, тодорхойгүй нөхцөл байдал, тодорхойгүй хугацаанд үргэлжилснээр харилцах, хадгаламжийн гарах урсгал ихтэй байх магадлалтай. Иймд хувь нийлүүлэгчээс хөрөнгө оруулах бодит боломжтой эсэхийг нотлох баримтусгай төлөөлөгчэй биш бол богино хугацаанд буюу сараас ихгүй хугацаанд хүлээн дараагийн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хэрэв хувь нийлүүлэгчээс хөрөнгө оруулах санал гаргаснаар БӨТ-г хэрэгжүүлэх хугацааг хойшлуулбал банкны харилцах, хадгаламжийн гарах урсгал нэмэгдэж банкнийг богино хугацаанд бэлэн мөнгөгүй болгон олон нийтийг сандралд оруулах өндөр эрсдэлтэй. Үүнээс шалтгаалан банкинд учрах алдагдлын дүн нэмэгдэхийн зэрэгцээ албадан татан буулгаж банкнийг хаах түвшинд хүргэнэ.

Иймд санал авах хугацааг Монголбанктэй зөвшилцөн маш тодорхой хугацаатай байх шаардлагатай.

Албадан татан буулгах нөхцөлд:

Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр томилогдсон тусгай төлөөлөгч нь БӨТ-г боловсруулах явцад дараахь нөхцөл байдал үүсвэл банкнийг албадан татан буулгах саналаа МБЕ-д гаргана:

- Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө амжилтусгай төлөөлөгчэй хэрэгжих бодит нөхцөл байхгүй;
- БӨТ хэрэгжүүлэх шаардлагагүй болсон Банкны тухай хуулийн заалт;
- бодит мөнгөн хөрөнгөөр дахин хөрөнгөжүүлэх тодорхой боломж байхгүй;
- актив, пассивыг бусад банкинд шилжүүлэх боломж байхгүй;
- Актив, пассивыг үнэлэх, БӨТ-г боловсруулах явцад банкны харилцах, хадгаламж, эх үүсвэрийн үндсэн суурь бүхэлдээ алдагдаж, пассив үлдээгүй;
- Гэмт хэргийн шинжтэй үйлдүүдээс шалтгаалж хуурамч, хий актив, пассив их хэмжээгээр илэрсний улмаар хариуцагч, нэхэмжлэгч нарын жинхэнэ эзэд нь тодорхойгүйн улмаас АПШ, ТБЗ байгуулах зэргээр АПШ-сний дараа шилжүүлэн авсан банкинд хүндрэл учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн;
- Олон нийтийн итгэл алдарч, АПШ, Тусгай зориулалтын банк -нд хүлээлгэн өгсний дараа ч банкны системд учирч болзошгүй эрсдэл өндөр болсон;
- Банкны актив, пассив, тэнцлийн гадуурх үүргүүд болон бусад гэрээ, хэлцлийн улмаас банкны актив, пассивыг үнэлэх боломжгүй буюу шүүх, цагдаа, хяналтын байгууллагаар

шийдвэрлүүлсний дараа үнэлэх боломжтойн улмаас 270 хоногоос дээш хугацаанд шийдэгдэхээргүй бол;

- Бусад шалтгаанаар БӨТ-г хэрэгжүүлэх нь татан буулгахаас илүү нийгэм, эдийн засаг, нийгмийн хохирол бага, санхүү банкны системд үзүүлэх дам нөлөө, эдийн засгийн өсөлтөд учруулах сөрөг нөлөө багатай байх хувилбар гэж үзвэл.

Төлөвлөгөө амжилтгүй болсон үед авах арга хэмжээ:

- БЭХА томилох;
- Дампуурлын хэрэг үүсгэх;
- Хувь нийлүүлэгчдийн хурлаар татан буулгах.

**Хохирлын үнэлгээ:** Банкны хадгаламж, харилцах, өр төлбөр, үүрэг гүйцэтгүүлэгч нараас тодорхой хэмжээний дүнг банкны актив хөрөнгөөр барагдуулах боломжгүй болох магадлалыг тооцоолж, эдгээр кредиторчуудын жагсаалт, хохирлын дүн, хувь хэмжээг гаргана.

### **ШИЙДВЭРИЙН САНАЛ:**

**Шийдвэрийн саналд хувилбаруудаас аль хувилбар нь өр төлбөрийг илүү барагдуулж, банкны системд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай байх талаарх харьцуулсан саналыг арга хэмжээ авах хугацааны хамт Монголбанкны Ерөнхийлөгчид хүргүүлнэ.**

Жишээ нь:

- Хувьцааны үнийг бууруулж, шинэ хувьцаа эзэмшигчээс хөрөнгө оруулж банкныг буцаан хэвийн үйл ажиллагааг хангах;
- Актив, пассивыг бусдад шилжүүлсний дараа банкныг татан буулгах;
- Тусгай зориулалтын банк байгуулж, Тусгай зориулалтын банк -д банкны бүх АПШ-ж Тогтворжуулалтын сангаас хөрөнгө оруулж, 3 жилийн хугацаанд хувьчлах, актив, пассивгүй үлдсэн банкныг татан буулгах;
- Тусгай зориулалтын банк байгуулж, Тусгай зориулалтын банк -д банкны АПШ-сний дараа банкныг татан буулгах;
- Актив, пассивын зарим хэсгийг бусдад шилжүүлж үлдсэн хэсгээр Тусгай зориулалтын банк байгуулах;
- Өрийн хувьцаанд хөрвүүлж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх гэх мэт.

### **Тав. Загвар хавсралтууд:**

- Банкны удирдлагаас хүлээн авсан тэнцэл, санхүүгийн тайлан, мэдээ;
- Банкны актив, пассивын үнэлгээний тайлан;

- Банкны хамгийн сүүлийн тэнцэл, орлогын тайлан, бусад шаардлагатай мэдээ;
- БӨТ-г хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох тушаал, шийдвэрүүдийн төсөл;
- Бусад судалгаа, мэдээ, мэдээлэл.

\_\_\_\_\_ БАНКИНД ТОМИЛОГДСОН  
ТУСГАЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ

МОНГОЛБАНКНЫ АЖЛЫН ХЭСЭГ

Банкинд албадлагын арга хэмжээ авах  
журмын хоёрдугаар хавсралт

## БЭТ, ТТ, БЭХА-Н АЖЛЫН УДИРДАМЖИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

1. **Тусгай төлөөлөгч (зөвлөл) нь** Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Иргэний хууль, энэ удирдамж, Монгол Улсын бусад хууль тогтоомж, Монголбанкны удирдлагаас өгөх үүрэг даалгаврын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
  2. Тусгай төлөөлөгч нь дараахь үндсэн арга хэмжээг шуурхай авна:
    - 2.1. Тусгай төлөөлөгч нь банк, түүний газар, салбар нэгжүүдийн бүх эд хөрөнгө, бичиг баримт (зээлийн хувийн хэрэг, гэрээ гм), үндсэн гүйлгээний системд хандах эрхүүд, актив хөрөнгийг бүрэн хяналтандаа авах, томилогдсон үеийн байдлаар (тасалбар болгосон өдрөөр) санхүүгийн тайланг аль болох дэлгэрэнгүй байдлаар Гүйцэтгэх удирдлагаас баталгаажуулсан байдлаар хүлээн авах.
    - 2.2. Тусгай төлөөлөгч томилогдсон, ажил хүлээлцэх завсрын үед аливаа үргүй зардал гарах, албан тушаалаа урвуулан ашиглах, залилан мэхлэх, луйвардах, хөрөнгө шамшигдуулах, эвдрэх, хяналтгүй болох, зэрэг явдлыг гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах,
    - 2.3. Банкны актив, пассивыг Банкны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.7-р заасны дагуу үнэлүүлнэ. Үнэлгээтэй холбоотой асуудлаар Монголбанкинд зохих мэдээллийг өгөх,
    - 2.4. Актив, пассивын үнэлгээг үндэслэн банкны ашиг, алдагдлыг тооцож өөрийн хөрөнгийн дүнг тодорхойлно.
    - 2.5. Тусгай төлөөлөгч нь \_\_\_\_\_ банк ХХК-д бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг Монголбанкнаас томилсон ажлын хэсгийн хамт Банкны тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан хэрэгслүүдийг хэрхэн авч хэрэгжүүлэх талаарх санал, дүгнэлтийг боловсруулан ажлын 15 хоногийн дотор Монголбанкинд танилцуулна. Төлөвлөгөөг боловсруулахдаа авч болох арга хэрэгсэл, арга хэмжээний хувилбаруудыг тоон болон чанарын үзүүлэлтээр харьцуулан банкнаас төлөх өр төлбөрийг хамгийн ихээр барагдуулах, банкны хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой болгох, банкны системд үүсгэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, Төрөөс гарах зардлын хэмжээг бага байлгах зарчмыг баримтална.
    - 2.6. Пассив буюу харилцах хадгаламжийн стратеги: Даатгагдсан, хадгаламжийг Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран тооцон гаргах, даатгагдаагүй хадгаламжийн асуудалд олон нийтээс асуух асуултад зохих хариу мэдээллийн бэлтгэсэн байх, Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаа нь олон нийтийн анхаарлын төвд байх тул нийтэд мэдээлэл өгөхдөө хянуур хандаж, мэдээллийн хэрэгслийн байгууллагын ажилтнуудтай зөв харьцаж байх нь харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг бууруулахгүй байх нэг үндэс болдгийг анхааралдаа авна. Тусгай төлөөлөгч нь банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудалд Монголбанкнаас баримталж буй бодлого, мэдээлэлд үндэслэн зөв, товч, тодорхой, оновчтой хариулт өгөхийг эрхэмлэнэ.
- Банкинд авах арга хэмжээ хэрэгжүүлж байгаа банкны хөрөнгийг Монголбанкны зөвшөөрөлгүйгээр зарах, шилжүүлэх, хуваарилах, захиран зарцуулахыг хориглоно.
3. Тусгай төлөөлөгчийн зөвлөл нь дараахь ажлыг хэрэгжүүлэхдээ зөвлөлийн гишүүдэд ажлын ачааллыг тохируулж, эрх, үүргийг давхардуулахгүйгээр хуваарилна:

- Бүтцийн өөрчлөлтийн талаар:
  - Банкинд хөрөнгө оруулахыг тухайн банкны хувь нийлүүлэгчдээс шаардах;
  - Банкны хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгийг Банкны тухай хуулийн 55.1.3-р зүйлийн дагуу алдагдлыг хүлээлгэн хорогдуулах,
  - Банкны дүрмийг шинэчлэн хувьцааны үнэлгээг өөрчлөн тогтоож Улсын бүртгэлд бүртгүүлэх,
  - Банкны тухай хуулийн дагуу бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, Монголбанкинд танилцуулах,
  - Монголбанкны баталсан бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх,
  - Банкны актив, пассивын үнэлгээг хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр стандарт, шаардлагын дагуу яаралтай хийлгэх.
  - Хадгаламжийн даатгалын корпорацитай мэдээлэл солилцож, даатгагдсан хадгаламжийн асуудлаар хамтран ажиллах,
  - БӨТ-ний дагуу актив, пассивыг бусад банкинд шилжүүлэх тохиолдолд шилжүүлэх гэрээ, санхүүгийн гүйлгээ, хөрөнгийн биет хүлээлцэх акт, эдгээрийг хариуцах эзэн, цаг хугацааг тусгсан ажлын төлөвлөгөө гаргаж Тусгай төлөөлөгчийн тушаал баталж хэрэгжүүлэх,
  - Туслах ажлын хэсгээс тайланг хүлээн авсан хувийг Монголбанкны архивт адил хувийг өгнө.
  - Туслах ажлын хэсгээс зээлийн хувийн хэрэг тус бүрийг лацадсан байдлаар хүлээн авч, хамтран товъёог үйлдэн хүлээн авна.
  - хэрэв ердийн журмаар олгогдоогүй зээл (жишээ нь дампуурч буй компанид олгосон, ХН-чийн компани, хуурамч буюу дүр үзүүлсэн компанид олгосон зээл, авлага, үнэт цаас зэргийн хувийн хэргийг шаардлагатай бол ажлын хэсэг байгуулж хүлээн авах нь зүйтэй.)-ийн хуви йн хэргийг тусгайлан авч үзэж эргэн төлөлт, эрсдэли йн сан байгуулсан хувийг харглалзан тусгай ажлын хэсэг томсилж болно.
  
- Захиргаа, хүний нөөцийн ажлууд:
  - Тусгай төлөөлөгчийн ажиллах хугацаанд банкны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх эсэхийг БӨТ-тэй уялдуулж гаргах,
  - Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаанд шаардлагатай ажилтнуудыг нэн даруй ажилд авах, шаардлагатай ажилтнуудыг ажлаас чөлөөлөх,
  - Бүх ажилтны НДД-ийг тусгай төлөөлөгчийн зөвлөлийн гишүүнд хадгалуулж, чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, бүтцийн өөрчлөлтөөр халагдсан ажилтнуудтай тойрох хуудсаар тооцоо хийж тусгай төлөөлөгчийн зөвлөл эцсийн байдлаар НДД, бусад бичиг холбогдох бичиг баримт, тушаалыг олгох,
  - Бүх ажилтнуудад өгөх мэдээллийг тусгай төлөөлөгчийн зөвлөлөөр хэлэлцэж, хурлыг зохион байгуулалтусгай төлөөлөгчэй, товч тодорхой хийх,
  - Банкнаас харилцагч, хадгаламж эзэмшигчтэй харилцдаг салбар, нэгж, үйлчилгээний утас, цахим талбар зэрэгт товч тодорхой мэдээллийг хоёрдмол санаагүй нийтэд мэдээлэх,

- Аж ахуй, үйлчилгээний ажлын гэрээ, хэлцлийн жагсаалтыг гаргаж, Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусдыг нь цуцлах, цаашид төлбөр гаргахыг зогсоох,
- Биет хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, ашиглалт, худалдан борлуулах асуудлууд,
- Улсын бүртгэлийн гэрчилгээ зэрэг банкны үндсэн бичиг баримт, Банкны болон банкны үйл ажиллагааны зөвшөөрлийн гэрчилгээн үндсэн эх хувийг хадгалах,
- Бичиг хэрэг, архивын чиглэлээр:
  - Банкны төв, бүх газар хэлтэс, салбар нэгжийн архивыг тоолж, шалгаж, шаардлагатай бол боловсруулалт хийж, зохих стандарт шаардлагыг хангасан байдлаар бүртгэл, хадгалалт, хамгаалалтын арга хэмжээг авах,
  - Бичиг хэргийн үзлэг, тооллого хийж, бүрэн хяналтыг тогтоох,
  - Тусгай төлөөлөгчийн бичиг хэрэг (тушаал, шийдвэр, тэмдэглэл, ирсэн, явсан бичиг гм)-ийг банкны өмнөх бичиг хэргээс тусгаар байдлаар шинээр дугаарлаж хөтлөх,
- Хөрөнгийн бүртгэл, тооцоо, төлбөрийн асуудлаар:
  - Шаардлагатай тохируулгын гүйлгээг хийх, (Хөндлөнгийн үнэлгээг үндэслэх үү? активын ангилалын журмаа барих уу?)
  - Банкны цахим мэдээлэл, гүйлгээний баримт бичгийн аюулгүй байдал, нууцлалын асуудлыг судалж, шаардлагатай бол зохих арга хэмжээг авах,
  - Тусгай төлөөлөгчид туслах ажлын хэсгийн мэдээ, тайланг хүлээн авч хөрөнгийн тооллого явуулсантай адил бүртгэл хийгдэж чадсан бол хөрөнгийн илүүдэл, дутагдлын тохируулгын гүйлгээ хийх, хэрэв хөрөнгийн тооллоготой дүйцэхүйц бус бол эд хөрөнгийн тооллогыг 5 хоногийн дотор эхлүүлж 10 хоногийн дотор дуусгах,
  - Тэнцэлд тусгагдсан актив хөрөнгийн бичиг баримтын биет байдлаарх бүрэн бүтэн байдал, хууль эрх зүйн өмчлөх, эзэмших, захиран зарцуулах, шаардах эрх бүрэн эсэхийг нягтлан шалгах замаар бүрэн хяналтдаа авах,
  - Бусдын эзэмшил, ашиглалт, хяналтад байгаа банкны биет болон биет бус хөрөнгийг буцаан авч, банкны эзэмшил, хяналтад авах,
  - Татварын шалгалтыг хүсэлт гарган яаралтай оруулж, татварын өр, төлбөр, авлагатай эсэхийг тогтоолгох,
  - Банкинд хэрэглэж байгаа бүх тэмдэг, дардас, лац, лоМонголбанко зэрэг санхүүгийн болон эд хөрөнгийн байдалд нөлөөлөхүйц хэрэгслүүдийн жагсаалт гаргах, эзэмшиж буй этгээдүүдийн жагсаалт гаргаж, шаардлагатай хязгаарлалт, хяналтыг тавих,
  - Монголбанкинд Тусгай төлөөлөгчийн тусдаа данс нээлгэх
  - Гадаад улсад байршуулсан мөнгөн хөрөнгө, биет болон биет бус хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг яаралтай лавлагаа явуулах замаар битүүмж, барьцаа, үүргийн гүйцэтгэлийн хязгаарлалтусгай төлөөлөгчэй эсэхийг тодруулж, шаардлагатай бол зохих арга хэмжээг авч татах,



- Монголбанкинд тогтоосон хугацаанд ажлын тайлангаа хүргүүлэх. Шаардлагатай тохиолдолд тухай бүр тайлан, танилцуулга, санал хүсэлт, тайлбарыг хүргүүлнэ.
  - Нийгмийн даатгалтай яаралтай тооцоо нийлж, өглөг, авлагын үлдэгдэл байгаа бол бүртгэлтэй тулган нягтлах,
- **Зээл, авлагыг барагдуулах:**
    - Активын чанарыг сайжруулах, зээл авлагыг төлүүлэх, өр төлбөрийг бууруулах замаар алдагдлыг аль болох багасгахтай холбоотой арга хэмжээг авах,
    - Банкнаас хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр оролцож, зохих мэдээллийг авч, хяналтаа тогтоох,
    - БӨТ-ний дагуу зээл, авлагыг бусад банкинд шилжүүлэх,
    - Банкны хадгаламж эзэмшигч, харилцагчид өгөх төлбөрөөс тухайн хадгаламж эзэмшигч, харилцагчдаас авах зээл, хүү болон бусад авлагыг суутгах тооцоог гаргах,
    - Үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй актив, пассивын жагсаалт гаргах,
    - Шаардлагатай тохиолдолд зээл, хүү, бусад үүргийн үлдэгдлийг зээлдэгчтэй тулган баталгаажуулалт хийх,
    - Зээлийг эргэн төлүүлэх ажлын төлөвлөгөө гарган чанаргүй зээлтэй ажиллах багыг шинэчлэн зохион байгуулах,
    - Зээл, авлагын хувийн хэргийг нэг бүрчлэн бүртгэж, зээлийн хувийн хэргийг зээлтэй ажиллаж төлүүлэх ажилтнаас тусгаар хадгална,
    - Зээлийн хувийн хэрэг хариуцсан ажилтан нь зээлийн хувийн хэргийг цахимжуулж, зээл, авлага барагдуулах ажилтнууд цахимаар ашиглах боломжоор хангана. Шаардлагатай үед зээлийн үндсэн бичиг баримтыг актаар холбогдох ажилтанд өгч, тогтсон хугацаанд буцаан авна.
    - Зээл, авлагын багц, бүлэг тус бүрээр судалгаа хийж, шүүхэд хандах, цагдаад хандах шаардлагатай зээлийн жагсаалтыг гаргаж нэхэмжлэл, гомдлоо үндэслэл сайтай боловсруулж цаг алдалгүй шүүх хурлыг хуралдуулахад анхаарлаа хандуулах шаардлагатай,
- **Хууль, эрх зүйн чиглэлээр:**
    - Банкны өмчлөл, эзэмшилд байгаа, байх ёстой хөрөнгө, эрхүүдийн өмчлөх эрх, барьцааны эрхийг зохих байгууллагууд (ҮХЭХБүртгэл, Газрын алба, Оюуны өмчийн газар, ҮЦГТХТөв, Авто тээврийн газар гм)-аас лавлах байдлаар зохих эрхүүд хязгаарлагдсан эсэхийг тодотгох,
    - Банкныг төлөөлөн гадагшаа харилцдаг салбар, нэгж, захирал, дарга нарын эрхийг хянаж, зохих өөрчлөлтийг оруулж байнга харьцдаг байгууллагууд болох улсын бүртгэлийн болон бусад байгууллагуудад зохих мэдээлэх,
    - Үйлчилж байгаа, хаагдаагүй бүх гэрээ (зээл, хадгаламж, харилцах, эх үүсвэрийн гэх мэт үндсэн үйл ажиллагааны гэрээнээс бусад)-ний жагсаалтийг гаргах, хэрэгжилтийг хянаж, цуцлах эсэх шинжилгээ, хуулийн үр дагаварыг тооцно. Жагсаалтад гэрээний хугацаа, үнийн дүн, үүргийн дүн, холбоотой этгээдийн байгуулсан эсэх зэрэг эрсдэлийг тусгах.

- Бүх төрлийн, бүх шатны шүүхэд хариуцагч, нэхэмжлэгч, гуравдагч этгээд, хохирогч, оролцогч, гэрч зэргээр банк хамааралтай болсон хаагдаагүй (эцэслэгдээгүй) бүх хэргийн жагсаалтыг гаргаж, шүүх хурлуудад оролцох төлөөллийг хэвээр үргэлжлүүлэх, өөрчлөх эсэхийг шийдэж, цаашид гарах үр дагаварыг судалж зохих итгэмжлэлийг цуцлах, олгох зэрэг асуудлыг яаралтай шийдэх,
  - Шүүхийн хэрэг тус бүрийн явц, тайлбар өгөх хугацаа зэргийг хянах хяналтын тогтолцоог гаргаж, түүнийг тусгай төлөөлөгчид буюу тусгай төлөөлөгчийн зөвлөлд тогтсон хугацаанд, шаардлагатай тохиолдолд тухай бүр танилцуулах,
  - Бүх төрлийн, бүх шатны шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд нэхэмжлэгч, төлбөр хариуцагч, хохирогч, гуравдагч этгээд, гэрч зэргээр оролцож байгаа, хаагдаагүй (эцэслэгдээгүй) хэргийн жагсаалт гарган хэрэг тус бүрийн явц, тайлбар өгөх хугацаа зэргийг хянах хяналтын тогтолцоог гаргаж, түүнийг тусгай төлөөлөгчийн зөвлөлд тогтсон хугацаанд, шаардлагатай тохиолдолд тухай бүр танилцуулах,
  - Гэмт хэргийн шинжтэй аливаа үйлдлийг Монголбанкинд мэдэгдэхийн зэрэгцээ зохих хууль, хяналтын байгууллагаар шалгуулах,
  - Үйлчилж байгаа, хаагдаагүй гэрээнүүдийн хэрэгжилт, цуцлах эсэх шинжилгээ, хуулийн үр дагаварыг тооцсон судалгааг яаралтай гаргаж тусгай төлөөлөгчийн зөвлөлөөр хэлэлцэх,
  - Банкны өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны эрэмбэ Монголбанкийг гаргаж, тохирсон хяналтыг тогтоох,
- **Мэдээллийн технологи (МТ), цахим аюулгүй байдлын чиглэлээр:**
    - Банкны үндсэн болон дэд системд нэвтэрдэг эрхүүдийн жагсаалт гарган хаах, тусгай төлөөлөгчийн зөвлөлөөр хуралдаж шаардлагатай эрхүүдийг буцаан олгох,
    - Гүйлгээний болон хяналтын эрхүүдийн логыг хянаж байх,
    - тусгай төлөөлөгчийн зөвлөлийн гишүүд нь банкны МТ-ийн бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо, эрхийн хүрээ, хязгаар, хяналт, эрсдэлийн талаар МТ-ийн удирдах ажилтнуудаар танилцуулга хийлгэж, ойлгож авах,
    - Банкны мэдээллийн бааз, мэдээллийн архив, нөөцийн биет болон цахим аюулгүй байдлыг хангах,
    - Банкны цахим орчны болон гүйлгээ, сервер зэргийн аюулгүй байдлыг хангах,
    - Тусгай төлөөлөгч ажиллах хугацааны төлбөр тооцоо, гүйлгээний аюулгүй байдлыг хангах;
    - Банкны сервер, цахим хуудас, цахим шуудан, дотоод программ хангамжинд хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангах;
    - Банкны ажилтан, удирдах албан тушаалтан, Тусгай төлөөлөгчийн багийн гишүүдийн банкны системд хандах эрхийн түвшинг тогтоох, хяналт тавих.
  - **Хадгаламжийн даатгалын чиглэлээр:**
    - Даатгагдсан хадгаламжийн тооцоог гаргах, шалгах,
    - Хадгаламжийн даатгалын корпораци-тай мэдээлэл солилцох,

- Даатгагдаагүй хадгаламжийн талаар баримтлах бодлого, нийтэд өгөх мэдээллийг Монголбанк, хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран бэлтгэх,

5. Банкны үйл ажиллагааг удирдахдаа дараахь баримт бичгүүдтэй танилцсан байх шаардлагатай:

- 5.1. Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорациас сүүлийн 3 жилд хийсэн хяналт шалгалтын тайлан танилцуулга;
- 5.2. Хөндлөнгийн аудитын сүүлийн 2 тайлан;
- 5.3. Сүүлийн 6 сарын санхүүгийн тайлан, Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийн биелэлт, бусад тайлан, тодруулгууд;
- 5.4. Активын хувийн хэрэг, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын байдал;
- 5.5. Гадаад, дотоодын шүүх, арбитраж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, гэрч, холбогдогч зэрэг аливаа хэлбэрээр оролцож буй бүх хэргүүд,
- 5.6. ШГА-нд үүрэг гүйцэтгүүлэх, үүрэг хүлээсэн, гуравдагч этгээд зэргээр сонирхол нь зөрчигдөж буй хэргүүд,
- 5.7. Банкны ТУЗ-ийн сүүлийн 2 жилийн хурлын материал, тэмдэглэл,
- 5.8. Гүйцэтгэх удирдлагаас гаргаж байсан тушаал, шийдвэрүүд, хэлэлцсэн хурлын тэмдэглэлүүд, байгуулсан гэрээ хэлцлүүд;
- 5.9. Банкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу гүйлгээг бүрэн хийж бүртгэлд үнэн зөв тусгаж байсан эсэх, түүнчлэн ашиглаж буй нягтлан бодох бүртгэлийн програм хангамж нь шаардлага хангаж байгаа эсэх;
- 5.10. Бичиг хэрэг (гадаад, дотоодын харилцагчаас ирсэн, тэдгээрт хүргүүлсэн албан бичгүүд, өгсөн хариу)
- 5.11. Архивын бичиг баримтын хадгалалт, хамгаалалт, бүрэн байдлын аюулгүй байдлыг хангасан эсэх, Туслах ажлын хэсгийн хүлээн авсан тайлан;
- 5.12. Банкны хөлсөлж авсан буюу гэрээгээр гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээний чанар, байдал, биелэлт;
- 5.13. Бусад.

Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг архивлан Монголбанкны архивт хадгална, банкны үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын гүйлгээ, тайлан мэдээ зэргийг тухайн банкных нь архивт, хэрэв банк болон Монголбанкинд аль алинд хадгалах шаардлагатай бол Монголбанкны архивт хуулбар үнэн тэмдэг дарсан хувийг хадгалахаар зохион байгуулна. Архивт цаасан болон цахим хэлбэрээрх мэдээлэл, гүйлгээ, банкны систем, нөөц сервер гм-г хамруулах шаардлагатай.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

**БАТЛАВ.**

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ \_\_\_\_\_

**БАНКНЫ НӨХЦӨЛТ УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН/**

**БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ АВСАН/**

**БАНКНЫ ЭРХ ХҮЛЭЭН АВАХ АРГА ХЭМЖЭЭ АВСАН**

\_\_\_\_\_ **БАНК ХХК-Д ТОМИЛОГДСОН**

**БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ /ТУСГАЙ ТӨЛӨӨЛӨГЧ/ БАНКНЫ ЭРХ ХҮЛЭЭН  
АВАГЧИД ТУСЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ҮЛГЭРЧИЛСЭН УДИРДАМЖ**

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1.Монголбанкны Ерөнхийлөгчийн 20\_\_ оны \_\_ дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар тушаалын дагуу \_\_\_\_\_ банкинд Онцгой дэглэм тогтоож/Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авч/Банкны эрх хүлээн авах арга хэмжээ авч, Бүрэн эрхт төлөөлөгч/Тусгай төлөөлөгч/Банкны эрх хүлээн авагч (цаашид БЭТ/ТТ/БЭХА гэх)-ийг томилсонтой холбогдуулан тус банкны төв, салбар, тооцооны төв, нэгжүүдийн актив, пассив хөрөнгийг бүртгэн, тоолж, нягталж, хянаж биет байдлаар болон бичиг баримтаар, цахимаар акт үйлдэн хүлээн авч, банкны БЭТ/ТТ/БЭХА-ийн хяналтад шилжүүлж хүлээлгэн өгөхөд энэ удирдамжийн зорилго оршино.
- 1.2.Монголбанкнаас \_\_\_\_\_ банкинд томилогдсон БЭТ/ТТ/БЭХА-д туслах ажлын хэсэг нь энэ удирдамжийн дагуу 20\_\_ оны \_\_ дугаар сарын .....-наас ..... -ны өдрүүдэд ажиллана.
- 1.3.БЭТ/ТТ/БЭХА-д туслах ажлын хэсэг нь Банкны тухай хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, “Банкинд албадлагын арга хэмжээ авах, хэрэгжүүлэхэд мөрдөх журам” болон энэ удирдамж, Монголбанкнаас тухай бүр өгөх чиглэл, заавар, удирдамж, зөвлөгөө, санамжийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4.Туслах ажлын хэсгийн ерөнхий ахлагч нь бүх ажлын хэсгүүдийг зохион байгуулах, Монголбанкнаас шаардлагатай хөрөнгө, зардал гаргах, цаг хугацаа, ажлын цаг, хамгаалалт, унаа, холбооны хэрэгслээр хангах зэргээр Монголбанк, туслах ажлын хэсгийн ажлуудыг удирдлага, зохион байгуулалт, ажиллах боломж нөхцөл, аюулгүй байдлаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Туслах ажлын хэсгийн ахлагч нь Монголбанкны Тамгын газрын удирдах буюу ахлах албан тушаалтан байх нь зохимжтой.
- 1.5.Туслах ажлын салбар, нэгж, алба зэрэгт ажиллаж байгаа Монголбанкны ажилтнуудыг нэгдсэн ойлголт, мэдээлэл, удирдлага, тайланг нэгтгэх ажлыг хангах ажлыг хариуцсан Улаанбаатар хот болон Монголбанкны салбаргүй газруудыг хариуцах дэд ажлын хэсэг, Монголбанкны салбар бүхий орон нутгийн салбар нэгжүүдийг хариуцсан дэд ажлын хэсэг тус тус 2-4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.
- 1.6.Туслах ажлын хэсгийн ажилтай холбоотой зардлыг Монголбанкнаас гаргана.
- 1.7.Ажлын хэсэг тус бүрийн ахлагч нь энэ удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж эхлэхээс өмнө \_\_\_\_\_ банкны төв, газар, хэлтэс, алба, салбар, тооцооны төв, касс, нэгжийн удирдлагад удирдамжийн 1.2-т заасан хугацааны эхний өдөр танилцуулна.
- 1.8.\_\_\_\_\_ банк нь Онцгой дэглэм тогтоох/Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах/Банкны эрх хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрэн хангаж, эд хөрөнгө, шаардлагатай тайлан, мэдээ, санхүүгийн болон бусад баримт материалыг ажлын хэсгийн шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгнө.
- 1.9.Ажлын хэсэг нь Банкны тухай хуулийн \_\_ дүгээр зүйлийн \_\_ -д заасан зарлал болох Хавсралт 2-1-ийг \_\_\_\_\_ банкны төв, салбар, нэгжийн байранд нийтэд харагдахуйц газар байрлуулж, харилцагч, олон нийтэд мэдэгдэнэ.

## ХОЁР. БАРИМТ МАТЕРИАЛ, ЭД ХӨРӨНГИЙН

### БҮРТГЭЛИЙГ ХӨТӨЛЖ, БАТАЛГААЖУУЛАХ

- 2.1. Ажлын хэсгийн ахлагч нь өөрийн томилогдсон салбар, тооцооны төв, нэгжийн удирдлага, бүх ажилтнуудыг байлцуулан \_\_\_\_\_ банк ХХК-д Онцгой дэглэм тогтоосон/Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авсан/Банкны эрх хүлээн авах арга хэмжээ авсан тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалыг танилцуулна.
- 2.2. Салбар, тооцооны төв, нэгжийн тухайн өдрийн бүх төрлийн нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг хяналтандаа авч, орлого зарлагын тайланг тухайн өдрөөр гаргаж, тайлан тэнцэл, тэнцлийн гадуурх дансдын үлдэгдлийг үндсэн баримт, акт, материалтай тулган шалгана. Дансдын үлдэгдэл үндсэн баримтаасаа зөрвөл, энэ талаар тус салбар, тооцооны төв, нэгжийн удирдлагад, холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэж, зөрүүг тохируулах, холбогдох байгууллагад асуудлыг тавьж, шаардлагатай бол бусад тайлан, мэдээ, материалыг нэмж гаргуулан авч Улсын байцаагчийн акт тогтоон зохих арга хэмжээг газар дээр нь авч ажиллахын зэрэгцээ энэ удирдамжийн хавсралтуудыг дор заасны дагуу үйлдэн банкны холбогдох ажилтанг байлцуулан баримтжуулж, акт үйлдэж гарын үсэг зуруулна:
- 2.2.1. Сейф, агуулах, бусад хайрцаг, сав, цүнх, автомашинд байгаа болон бусад газраас хүлээн авсан бэлэн мөнгийг хүлээлцэх актыг хавсралт 2-2-ын дагуу үйлдэнэ. Мөнгөн хөрөнгийн дансдыг тоолж шалгах үед илүүдэл, дутагдал гарвал шаардлагатай орлого, зарлагын гүйлгээг дараахь зүйлсийг харгалзан үзэж анхааран дор бүр нь хийнэ:
- Гадаад валютын хүчинтэй эсэх,
  - Замын чекийн бүрдлийг сайн хянаж, замд яваа чек бий эсэх,
  - Үнэ бүхий зүйлийг тусад нь бүртгэх,
  - Касс хүлээлцэхтэй холбогдох тайлбарыг дэлгэрэнгүй тодорхой бичих,
- 2.2.2. Үнэт зүйлсийг банкны холбогдох ажилтанг байлцуулан нүд үзэн тоолж, хүлээлцэх актыг хавсралт 2-3-ын дагуу,
- 2.2.3. Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн жагсаалтыг хавсралт 2-4-ийн дагуу,
- 2.2.4. Үнэт цаас (БХХО, УХХО)-ны жагсаалтыг хавсралт 2-5-ын дагуу,
- 2.2.5. Зээл, авлагын хувийн хэрэг, материалыг тэнцлийн үлдэгдэлтэй нэг бүрчлэн тулгаж, банкны холбогдох ажилтнаас хүлээн авч хүлээлцэх актыг хавсралт 2-6-гийн дагуу. Зээл, баталгаа, батлан даалт зэрэг хувийн хэргийг битүүмжлэн лацдаж дараагийн шийдвэрийн дагуу хүлээлцэх ажлыг гүйцэтгэнэ.
- 2.2.6. Зээл, авлагын барьцаанд хураан авсан, тэнцлийн гадуур бүртгэлтэй болон тайлан тэнцэлд тусгаагүй хөрөнгийн жагсаалтыг хавсралт 2-7-гийн дагуу,

- 2.2.7. Үндсэн хөрөнгө, эд хогшлын хяналтын карт, бүх үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, биет бус хөрөнгө тэдгээрийн өмчлөх гэрчилгээний жагсаалтыг хавсралт 2-8-ын дагуу,
- 2.2.8. Өмчлөх бусад хөрөнгийн жагсаалтыг хавсралт 2-9-ийн дагуу,
- 2.2.9. Авлага, бусад активын жагсаалтыг хавсралт 2-10-ын дагуу,
- 2.2.10. Материал, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл (БҮТЭЗ)-ийн жагсаалтыг хавсралт 2-11 а, 2-11 б-гийн дагуу,
- 2.2.11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын харилцах, хадгаламжийн дансны хяналтын карт, хадгаламжийн сертификат, гарын үсгийн баталгаа зэргийг тоолж, үлдэгдлийг тайлан тэнцэл нэрийн данс нэг бүртэй тулгах, мөн бусад өр төлбөрийн дансны үлдэгдлийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар болон харилцах, хадгаламж, өглөгөөр бүлэглэн нэг бүрчлэн жагсаалтыг хавсралт 2-12-ын дагуу,
- 2.2.12. Зээлийн шугам, батлан даалт, баталгаа, аккредитив, гэрээ болон хэлцлээр хүлээсэн ирээдүйд хэрэгжих бусад үүргүүдийг баримт бичигтэй нь нэг бүрчлэн тулган шалгаж жагсаалтыг хавсралт 2-13а-гийн дагуу, тэнцлийн гадуур бүртгэлтэй бусад зүйлсийн жагсаалтыг хавсралт 2-13б-гийн дагуу,
- 2.2.13. Архивын баримт материалын жагсаалтыг хавсралт 2-14-ийн дагуу,
- 2.2.14. Банкны холбогдох ажилтан, албан тушаалтны тамга, тэмдэг, лац, ломбо, тэдгээрийн дардас, ажилтнуудын системд хандах эрхийн жагсаалтыг хавсралт 2-15-ын дагуу тус тус үйлдэнэ.
- 2.2.15. Банкны тухайн нэгжид хадгалагдаж байгаа архивт өгөх бичиг баримт бичгийн жагсаалтыг гаргах,
- 2.2.16. Банкны тухайн нэгжид хадгалагдаж байгаа архивт өгөх хугацаа нь болоогүй бичиг баримт бичгийн жагсаалтыг гаргах,
- 2.2.17. Үнэт зүйлсийн хайрцгийг битүүмжлэн, данс бүртгэл, эзэмшигчдийн жагсаалтыг тулган баталгаажуулна.
- 2.2.18. Тухайн нэгжийн бүх удирдлага, ажилтнуудын системд нэвтрэх эрхийг хүчингүй болгон, шинэ эрхийг ажлын хэсгийн ахлагч оруулж, ажил хүлээлцэх, хянах хугацааны лог файлыг БЭТ/ТТ/БЭХА-ийн зөвлөлд хүлээлгэн өгнө.
- 2.2.19. Тухайн нэгжийн үйл ажиллагаанд ашиглаж буй бүх галт зэвс бүх удирдлага, ажилтнуудын системд нэвтрэх эрхийг хүчингүй болгон, шинэ эрхийг ажлын хэсгийн ахлагч оруулж, ажил хүлээлцэх, хянах хугацааны лог файлыг БЭТ/ТТ/БЭХА-ийн зөвлөлд хүлээлгэн өгнө.

- 2.2.20. Банк нь харуул хамгаалалтаа өөрөө хариуцдаг бол Монголбанкны нууц, аюулгүй байдлын алба хамгаалалтын түвшинд давхар хянах арга хэмжээг төрийн зохих байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.2.21. Хэрэв харуул хамгаалалтыг гэрээт гүйцэтгэгч хариуцдаг бол Монголбанкны нууц, аюулгүй байдлын алба тухайн компанийн удирдлагатай түр гэрээ хийх буюу төрийн зохих байгууллагатай хамтран шаардлагатай зохион байгуулалт, хяналтын арга хэмжээг авна.
- 2.2.22. Туслах ажлын хэсгийн ерөнхий ахлагч нь банкны хэмжээнд хэрэглэгдэж байгаа буу, галт зэвсгийн бүртгэлийг биет байдалтай нь тулган баталгаажуулах ажилд онцгой анхаарч тусгай төлөөлөгч ажиллуулж, бүртгэлгүй болон бусад зөрчилтэй асуудал байвал Цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.

## ГУРАВ. САЛБАР НЭГЖИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙГ ГАРГАХ

- 3.1. Энэ удирдамжийн 2.2.3-т заасан болон банкны ажилтнуудаас гаргуулан авсан бусад шаардагдах баримт материалыг үндэслэн банкны салбар, тооцооны төв, нэгжийн зээлийн ангиллыг хийж, хавсралт 2-16-гийн дагуу гарган тухайн салбар, тооцооны төв, нэгжийн удирдлага, нягтлан бодогч нараар гарын үсэг зуруулж баталгаажуулсны дараа нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг хийлгэж тэнцэлд тусгахаас гадна зээлийн эрсдэлийн сангийн тооцоог хийж, нэмж байгуулахаар тохиолдолд зардлаар газар дээр нь шууд байгуулна.
- 3.2. Банкны салбар, нэгжийн үнэт цаас, ӨБХ, авлагын ангиллалыг энэ удирдамжийн хавсралт 2-17-гийн дагуу гаргана. Активын ангилал өөрчлөгдсөн бол акт үйлдэж банкны салбар нэгжийн удирдлагад танилцуулан гарын үсгийг нь зуруулна.
- 3.3. \_\_\_\_\_ банкны салбар, нэгж дээр саатаж буй гүйлгээний жагсаалтыг энэ удирдамжийн хавсралт 2-18-ын дагуу гаргана.
- 3.4. \_\_\_\_\_ банкны салбар, нэгжийн хураангуй тайлан тэнцлийг энэ удирдамжийн хавсралт 2-19-ийн дагуу гаргуулан авч, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.5. \_\_\_\_\_ банкны салбар, нэгжийн орлого, зарлагын тайланг энэ удирдамжийн хавсралт 2-20-ийн дагуу гаргуулан авч, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.6. Салбар, нэгж хоорондын тооцооны үлдэгдлийн жагсаалтыг гаргуулан авч, салбар, нэгж хоорондын тооцооны үлдэгдлийг нарийвчлан шалгаж, хоорондын тооцоо таарч тохирч байгаа эсэхийг шалган хэрэв зөрүүтэй байвал шаардлагатай гүйлгээг хийлгэх ба газар дээр нь шийдвэрлэх боломжгүй тохиолдолд тайлбар гаргуулан авна.
- 3.7. Энэ удирдамжийн хоёр болон гуравдугаар хэсгүүдэд заасны дагуу акт үйлдэн хүлээлцэн авч жагсаалт гарган баталгаажуулсны дүнд хавсралт 2-21-ийн дагуу банкны эрх бүхий холбогдох ажилтнуудаас тодорхойлолт гаргуулан авна. Хэрэв тодорхойлолтод гарын үсэг зураагүй, үндэслэлгүй шалтгаанаар татгалзсан бол энэ тухай БЭТ/ТТ/БЭХА-ийн зөвлөлд цаг тухайд нь мэдэгдэж холбогдох арга хэмжээ авна.



## ДӨРӨВ. АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН ГАРГАХ, ХҮЛЭЭЛЦЭХ

- 4.1. \_\_\_\_\_ банкны салбар нэгж дээр ажилласан ажлын хэсэг нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа танилцуулгыг бичиж, энэ удирдамжийн хоёр болон гуравдугаар хэсэгт заасан баримт, материалын хамт БЭТ/ТТ/БЭХА-ийн зөвлөлд 20\_\_ оны \_\_ дугаар сарын ...-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө.
- 4.2. \_\_\_\_\_ банкны салбар, нэгж дээр ажиллах хугацаанд ямар нэгэн хүндрэлтэй асуудал гарсан нөхцөлд энэ талаар БЭТ/ТТ/БЭХА-ийн зөвлөлд болон Монголбанкинд тухай бүр нь мэдээлнэ.

### МОНГОЛБАНК

- 23.4.1. Банкинд хэрэглэгдэж байгаа бусад тэмдэг, дардас, лац, ломбо, хэвлэмэл хуудас зэрэг банкныг төлөөлж бичиг баримтыг баталгаажуулах, үнэт цаас хэлбэрийн хэвлэмэл хуудас зэргийн бүртгэлийг нэн даруй гаргаж зохих хяналтыг тогтоож, шаардлагатай ажилтнуудад зохих эрхийг олгоно;
- 23.5. Тусгай төлөөлөгчийн зөвлөл банкны дараахь баримт, бичигтэй яаралтай танилцана:
- 23.5.1. Банкинд Монголбанк, Хадгаламж даатгалийн корпораци, Санхүүгийн зохицуулах хорооноос сүүлийн 3 жилд хийсэн хяналт шалгалтын тайлан;
- 23.5.2. Сүүлийн 2 жилийн санхүүгийн аудитлагдсан тайлан;
- 23.5.3. Сүүлийн 6 сарын санхүүгийн тайлан;
- 23.5.4. Сүүлийн нэг жилийн хугацаанд хийгдсэн хамгийн том 100 гүйлгээ;
- 23.5.5. Банкны холбогдох этгээд болон харилцан хамаарал бүхий этгээдийн судалгаа, тайлан;
- 23.5.6. Гадаад, дотоодын шүүх, арбитраж банкнаас нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, гэрч, холбогдогч зэрэг аливаа хэлбэрээр оролцож буй бүх хэрэг;
- 23.5.7. Банкнаас шийдвэр гүйцэтгэх байгууллагадүүрэг гүйцэтгүүлэх, бусад этгээдийн өмнө үүрэг хүлээсэн, гуравдагч этгээдээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа зэргээр ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа болон зөрчигдөж болзошгүй хэргүүд;
- 23.5.8. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн сүүлийн 2 жилийн хурлын материал, тэмдэглэл.